



# ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ГАЗАР ОЛГОЛТ, ГАЗРЫН ТӨЛБӨРИЙН НОГДУУЛАЛТ,  
БҮРДҮҮЛЭЛТИЙН ҮР ДҮН”

АУДИТЫН КОД: ХОА-2024/30-04-ШТА-ГА

Ховд хот

2024 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061 Цахим хаяг: [Boldbaatar.khu@audit.gov.mn](mailto:Boldbaatar.khu@audit.gov.mn)

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545 Цахим хаяг: [tsetsegsurena@audit.gov.mn](mailto:tsetsegsurena@audit.gov.mn)

Ахлах аудитор: Д.Нарантуул

Утас: 70432545 Цахим хаяг: [Narantuuld@audit.gov.mn](mailto:Narantuuld@audit.gov.mn)

Ахлах Аудитор: Ц.Бадрал

Утас: 7043-2545 Цахим хаяг: [badralts@audit.gov.mn](mailto:badralts@audit.gov.mn)

Аудитор: Н.Батжаргал

Утас: 7043-2545 Цахим хаяг: [Batjargaln@audit.gov.mn](mailto:Batjargaln@audit.gov.mn)

Аудитор: А.Нарандэлгэр

Утас: 7043-2545 Цахим хаяг: [Narandelgera@audit.gov.mn](mailto:Narandelgera@audit.gov.mn)



**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2024 оны 12 сарын 06 өдөр

Дугаар А/32

Ховд

**Аудитын тайлан баталгаажуулах тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол улсын Ерөнхий аудиторын 2023 оны 10 дугаар сарын 5-ны өдрийн А/102 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтын 1.4 дэх хэсэг, 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Газар олголт, газрын төлбөрийн ногдуулалт, бүрдүүлэлтийн үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр хавсралтаар баталгаажуулсугай.
2. Аудитын зөрчлийн нэгтгэлийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг Гүйцэтгэл, нийцлийн аудитын газар, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, Ховд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга нарт тус тус хүргүүлсүгэй.
4. “Газар олголт, газрын төлбөрийн ногдуулалт, бүрдүүлэлтийн үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, үр дүнг 2025 оны 9 дүгээр сарын 25-ны дотор ирүүлэхийг Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, Аймгийн засаг даргад зөвлөсүгэй.
5. Ажлын болон нотлох баримтын иж бүрдлийг ханган архивд хүлээлгэн өгөхийг аудитор (Н.Батжаргал)-д, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж, гүйцэтгэлийн аудитын цахим системд иж бүрэн оруулахыг Гүйцэтгэлийн аудитын багт хариуцуулсугай.
6. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлагыг мэдээллээр хангаж ажиллахыг аудитын менежер (А.Цэцэгсүрэн)-д даалгасугай.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



*(Handwritten signature)*  
Х.БОЛДБААТАР



**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84140 Ховд, Жаргалант сум, Ховд аймаг  
Утас/Факс: 70433061

2024.12.06 № 462  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН  
ГҮЙЦЭТГЭЛ НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

Ховд аймгийн Төрийн аудитын газраас Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд “Газар олголт, газрын төлбөрийн ногдуулалт, бүрдүүлэлтийн үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг хүргүүлж байна.

Хавсралт ... хуудастай

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР **Х.БОЛДБААТАР**



**АГУУЛГА**

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР.....3

Графикийн товьёг .....3

Хүснэгтийг товьёг.....3

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл .....4

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ.....5

**БҮЛЭГ 1. ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨГ ЗӨРЧИЖ, ДУУДЛАГА ХУДАЛДАА ЗОХИОН БАЙГУУЛАХГҮЙГЭЭР ГАЗАР ОЛГОСНООР 1,445.2 САЯ ТӨГРӨГИЙН ОРЛОГО ТӨВЛӨРҮҮЛЭХ БОЛОМЖ АЛДСАН БАЙНА..... 6**

Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хууль журамд нийцүүлэн баталсан ч сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг зарим сумууд батлуулаагүй, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдаагүй газрыг олгожээ. ....6

Гэр, орон сууц, хашааны зориулалтаас бусад зориулалтаар газрыг олгоходоо дуудлага худалдаа зохион байгуулаагүйгээс 322.0 сая төгрөгийн орлого бүрдэх боломжийг алдсан байна .....12

**БҮЛЭГ 2 ГАЗРЫН ТӨЛБӨРИЙН ОРЛОГЫГ БҮРЭН НОГДУУЛААГҮЙ, ГАЗРЫН ТӨЛБӨРИЙН БҮРДҮҮЛЭЛТЭД ТАВИХ ХЯНАЛТЫГ ҮР НӨЛӨӨТЭЙ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА 15**

Газрын төлбөрийн орлогыг дутуу ногдуулснаас 406.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлэх боломж алдсан байна ..... 15

Газар олголт, газрын төлбөрийн орлогын бүрдүүлэлт ногдуулалтад аймаг, сумдын ИТХ болон Засаг дарга нар хуульд заасны дагуу хяналт хэрэгжүүлээгүй, өмнөх аудитын хэрэгжилт хангадаагүй, албан хаагчдын ажлын хариуцлага сул байна ..... 18

**ДҮГНЭЛТ: 20**

**АУДИТЫН ЗӨВЛӨМЖ: ..... 21**

Алдаа зөрчлийн нэгтгэлд шалгагдагч байгууллагаас ирүүлсэн санал, тайлбар: ..... 22

Алдаа зөрчлийн нэгтгэлд шалгагдагч байгууллагаас ирүүлсэн санал, тайлбар: ..... 24

Зөрчлийн нэгтгэлд ирүүлсэн санал тайлбарт ТАГ-аас хариу хүргүүлсэн тайлбар: 24

Аудитын тайланг баталсан тушаал: ..... 26

**ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР**

|          |  |
|----------|--|
| ААН      | Аж ахуйн нэгж  |
| АДБОУС   | Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт        |
| ГА       | Гүйцэтгэлийн аудит                                   |
| ГХБХБГ   | Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар       |
| ЗГ       | Засгийн газар  |
| ЗДТГ     | Засаг даргын тамгын газар                            |
| ИТХ      | Иргэдийн төлөөлөгчдийн хурал                         |
| ИНХ      | Иргэдийн нийтийн хурал                               |
| МУЕА     | Монгол улсын ерөнхий аудитор                         |
| ОНӨААТҮГ | Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар |
| ШТА      | Шууд тайлагнах аудит                                 |
| ТЕЗ      | Төсвийн ерөнхийлөн захирагч                          |
| ХОА      | Ховд аймаг дахь Төрийн аудитын Газар                 |
| УИХ      | Улсын их хурал                                       |
| ҮАГ      | Үндэсний аудитын газар                               |
| ХХК      | Хязгаарлагдмал хариуцлагатай компани                 |

**Графикийн товьёг**

| №        | Тайлбар  | Хуудасны дугаар |
|----------|--|-----------------|
| График 1 | Чөлөөлсөн газрын судалгаа  | 11              |
| График 2 | 2019-2023 онуудад гэр, орон сууц, хашааны газраас бусад зориулалтаар олгосон газрын мэдээлэл | 12              |
| График 3 | Газрын төлбөрийн орлогын биелэлт /хувиар/  | 17              |
| График 4 | 2019-2023 онуудын нийт газрын дуудлага худалдааны орлогын төлөвлөгөөний биелэлт              | 17              |

**Хүснэгтийг товьёг**

| №         | Тайлбар  | Хуудасны дугаар |
|-----------|--|-----------------|
| Хүснэгт 1 | Газар зохион байгуулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл                            | 7               |
| Хүснэгт 2 | Жаргалант сумын 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт | 8               |
| Хүснэгт 3 | Газар эзэмшүүлсэн, өмчлүүлсэн иргэдийн тоо                                 | 9               |
| Хүснэгт 4 | Өргөдөл, хүсэлт шийдвэрлэсэн байдал  | 10              |
| Хүснэгт 5 | Гэр бүлийн хэрэгцээнд 2019-2023 онуудад олгосон газар                      | 10              |
| Хүснэгт 6 | Газрын төлбөрийн ногдуулалт 2019-2023 он                                   | 15              |
| Хүснэгт 7 | Газрын төлбөрийн 2019-2023 оны орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл               | 16              |
| Хүснэгт 8 | Өмнөх аудитаар өгөгдсөн шийдвэрийн хэрэгжилт                               | 19              |

**Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдээгдэл**

|  |   |
|--|---|
| <b>Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:</b>                     | Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд, МУЕА-ын 2023 оны А/162 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын 2024 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө"-г үндэслэн гүйцэтгэлээ.   |
| <b>Аудитын зорилт:</b>                                     | Газар олголт, газрын төлбөрийн ногдуулалт, бүрдүүлэлтийн үр дүнд аудит хийж иргэд, олон нийт, аймгийн ИТХ болон холбогдох байгууллага, албан тушаалтнуудад мэдээлэхэд аудитын зорилго чиглэгдэнэ.<br>Аудитын зорилгыг хангахын тулд аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэлээ. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>• Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу газар олголт хийгдсэн үү?</li> <li>• Газрын төлбөрийн орлогыг бүрэн ногдуулж, хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлсэн үү?</li> </ul>  |
| <b>Аудитын хамарсан хүрээ:</b>                             | Аудитад Газрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хуулийн хүрээнд газар эзэмшүүлэх шийдвэр, газрын төлбөрийн орлогын ногдуулалт, бүрдүүлэлтийн талаар чиг үүрэг хүлээсэн төрийн байгууллага болох аймаг, сумдын ИТХ, Засаг дарга, аймаг, сумдын ЗДТГ, Татварын хэлтэс, ГХБХБГ-ын 2019-2023 оны газар олголт, газрын төлбөрийн ногдуулалт, бүрдүүлэлттэй холбоотой үйл ажиллагааг хамрууллаа. Хууль хяналтын байгууллагад шалгагдаж байгаа асуудлыг аудитад хамруулаагүй болно.   |
| <b>Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт:</b>                 | Аудитыг АДБОУС (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 "Төрийн аудит, тулгуур зарчим", MNS 6817-5:2020 "Төрийн аудит, гүйцэтгэлийн аудит" стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал"-д заасан арга зүйг ашиглан аудитын зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох зүйлсийг цуглуулах, нягтлан шалгах, баримтад дурдсан мэдээлэлд судалгаа, шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт хийх холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, тодруулга авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх, үр дүнг тооцох арга зүйг ашиглан дүгнэлт, зөвлөмж боловсруулав. |
| <b>Аудитын бүрэлдэхүүн, хугацаа:</b>                       | Аудитыг аймгийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар хянан удирдаж, аудитын менежер А.Цэцэгсүрэн аудитын стандарт, арга зүйн дагуу үе шатны хяналт хэрэгжүүлж, ахлах аудитор Д.Нарантуул, аудитор А.Нарандэлгэр, Ц.Бадрал, Н.Батжаргал нар аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 2024 оны 09 дүгээр сарын 06-аас 11 дүгээр сарын 30-ныг хүртэл хугацаанд хийж гүйцэтгэв.  |
| <b>Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл:</b> | Аудитын тайланг Төрийн аудитын газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж батлуулан, УАГ-ын удирдлагын зөвлөлийн хуралд аудитын үр дүнг танилцуулж, аймгийн ИТХ, Засаг дарга, холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэв.  |
| <b>Хүндрэл бэрхшээл:</b>                                   | ГХБХБГ-аас ирүүлсэн баримт материал, судалгаанууд иж бүрэн бус, архивын нэгж үүсгээгүй, албан хаагчдын ажлын хариуцлага сул зэрэг нь аудитыг гүйцэтгэхэд хүндрэлтэй байлаа.<br><br>Мөн Цэцэг, Чандмань, Мянгад сумууд газрын даамалгүй, Алтай сумын газрын даамал мэдээ, судалгааг ирүүлээгүй, Дарви сумын газрын даамал  |

жирэмсний чөлөөтэй, Булган сумын даамал нь судалгааг бүрэн гаргаж ирүүлээгүй зэрэг нь тоон мэдээ, судалгааг нэгтгэхэд бэрхшээлтэй байлаа

## ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Аймгийн ГХБХБГ нь Газрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хууль, салбарын бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган төрийн үйлчилгээг чанартай шуурхай хүргэхэд анхаарч, Газрын цахим шилжилт Монгол улсын хэмжээнд нэвтэрсэнтэй холбогдуулан төрийн үйлчилгээний цахим систем [www.emongolia](http://www.emongolia)-д нэгдэн [www.egazar](http://www.egazar)-ыг ашиглаж 17 сумын хэмжээнд цахим үйлчилгээг нэвтрүүлэн ажиллаж байна.

Мөн төрөөс газрын талаар баримталж буй бодлого чиглэлтэй уялдуулж, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 110 дугаар тогтоолоор улсын хэмжээнд хэрэглээнд нэвтэрсэн газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн үйл ажиллагааг эрхлэх ажлын хүрээнд:

- Хаягийн мэдээллийн систем,
- Газар зохион байгуулалт төлөвлөлтийн цахим систем
- Газрын кадастрын систем
- Газрын үнэлгээний систем зэрэг 4 үндсэн дэд системүүд дээр ажиллаж байна.

Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль хэрэгжиж эхэлсэн 2003 оноос 2023 оны 11 сар хүртэл аймгийн хэмжээнд газар өмчилсөн, эзэмшсэн иргэдийн тоо 25068 болж, нийт иргэдийн 27.8 хувь нь гэр бүлийн хэрэгцээний газартай болжээ.

Засгийн газрын 2023 оны 105 дугаар тогтоолоор “Иргэнд 2023 онд өмчлүүлэх газрын байршил хэмжээ”, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 10/10 дугаар тогтоолоор батлагдсан аймгийн Газар зохион байгуулалтын 2023 оны төлөвлөгөөний дагуу төсөвт байгууллагын зайлшгүй хэрэгцээнд 33 байгууллагад 85.83 га газар, гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 4759 иргэнд 377.11 га газар, төмс хүнсний ногооны зориулалтаар 377 иргэн, аж ахуй нэгж байгууллагад 944.06 га газар, мод үржүүлгийн зориулалтаар 106 байршилд 361 га газар, түгээмэл тархацтай ашигт малтмалын зориулалтаар 28 га тус тус өмчлүүлж, эзэмшүүлж, ашиглуулсан байна.

Аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 10 дугаар хуралдаанаар орон нутгийн 2023 оны төсөвт 30 хувийг, Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох төслөөс 70 хувийн санхүүжилтийг шийдвэрлэж, Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас тендер зарлаж, Газар дэлхий ХХК шалгаран гүйцэтгэж байна.

Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох төслийн санхүүжилтээр шинээр Зэрэг, Мянгад, Эрдэнэбүрэн сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг “Лапланд эко” ХХК, Алтай, Үенч, Дуут, Мөнххайрхан, Манхан, Дөргөн, Ховд сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг тодотгох ажлыг “Тэгш хэм групп” ХХК гүйцэтгэж байна. Зэрэг, Мянгад, Эрдэнэбүрэн сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний иж бүрдлийг газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас хянаж, дүгнэлт гаргасан байна.

**БҮЛЭГ 1. ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨГ ЗӨРЧИЖ, ДУУДЛАГА ХУДАЛДАА ЗОХИОН БАЙГУУЛАХГҮЙГЭЭР ГАЗАР ОЛГОСНООР 1,445.2 СЯА ТӨГРӨГИЙН ОРЛОГО ТӨВЛӨРҮҮЛЭХ БОЛОМЖИЙГ АЛДСАН БАЙНА.**

Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хууль журамд нийцүүлэн баталсан ч сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг зарим сумууд батлуулаагүй, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдаагүй газрыг олгожээ

1.1.1 Газрын тухай хуульд нутаг дэвсгэрийн хэмжээнд байгаль, газар зүйн нөхцөл, газрын нөөц, экологи, эдийн засаг, орон зайн багтаамж, чадавхад зохицсон газрын менежментийн бодлого хэрэгжүүлэх, нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх 12-16 жилийн хугацаанд хэрэгжүүлэх хэтийн чиглэл болох "газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө"-г баталж мөрдөхөөр хуульчилсан.

1.1.2 Аймаг газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөгүй нь өмнөх нийцлийн аудитаар илэрч, зөвлөмж өгөгдсөний дагуу аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлыг баталж, 2023 онд худалдан авах ажиллагааг зохион байгуулж, "Газар дэлхий" ХХК шалгаран 2025 оны 05 сард хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна.

1.1.3 Хот байгуулалтын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3<sup>1</sup>, Газрын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3.1<sup>2</sup>-д заасны дагуу Ховд хотыг 2030 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг 2015 онд магадлалаар баталгаажуулан Засгийн газрын 2017 оны 347 дугаар тогтоолоор батлагдсаныг мөрдөн ажиллаж, Жаргалант сумын нутагт дэвсгэрт Шинэ суурьшлын бүсэд 3, Бугат багийн нутаг дэвсгэрт 1 нийт 4 хэсэгчилсэн төлөвлөгөө баталсан байна.

1.1.4 Мөн шинэ суурьшлын бүсийн 20 га талбайд хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зураг төслийг 40.0 сая төгрөгөөр "Алтан орд констракшн" ХХК-иар хийж гүйцэтгүүлэх гэрээг байгуулж гэрээний дагуу ажлаа гүйцэтгээгүй байна.

1.1.5 Аймгийн хэмжээнд Дөргөн, Манхан, Алтай, Жаргалант сумууд сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй бусад 13 сум хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгүйгээр газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлан газар олгож байгаа нь цаашдаа эмх цэгцгүй газар олголт хийгдэх, газар чөлөөлөх, нүүлгэн суурьшуулах, газар чөлөөлөхтэй холбоотой маргаан үүсэх эрсдэлтэй байна.

1.1.6 Сүүлийн жилүүдэд бүтээн байгуулалтын ажил эрчимтэй явагдаж хотжилт, хүн амын болон үйлдвэр, аж ахуйн газруудын төвлөрлөөс хот, суурины хүн амын тоо жил ирэх тутам өссөнтэй холбоотой газар ашиглалтын зориулалт, хэмжээг өөрчлөх, хууль тогтоомж зөрчин барилга байгууламж барих зэрэг сөрөг үйл ажиллагаа гарч байгаагаас хот, сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй болох зайлшгүй шаардлага бий болж байна.

1.1.7 Ховд хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг түүвэрлэн хянахад дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- ✓ Бугат багийн Нисэх тосгоны 5 дугаар гудамжинд ногоон байгууламжаар тусгасан газарт Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор, 5-8 давхар нийтийн орон сууц барих зориулалтаар,
- ✓ Мөн өв соёлын хүрээлэн байгуулахаар төлөвлөсөн газарт сурын харвааны бэлтгэлийн талбайн газар, Хар ус нуурын сав газрын захиргаанд сургалт үйлдвэрлэлийн барилгын зориулалтаар тус тус газар олгосон,
- ✓ Цамбагарав багт Прогресс сургуулийн арын уулзварт байршилтай 2 давхар тоосгон барилгын газрыг улаан шугам давуулан олгосон,

<sup>1</sup> 3.1.3. "хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө" гэж хот, тосгоны хүн амын эрүүл, аюулгүй амьдрах, ажиллах таатай орчинг бүрдүүлэхэд чиглэгдсэн хот байгуулалтын үндсэн баримт бичгийг;

<sup>2</sup> аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний төслийг боловсруулах;

- ✓ Буянт багийн нутаг дэвсгэрт сургууль, цэцэрлэгийн барилга барихаар төлөвлөсөн газарт орон сууцны барилгын зөвшөөрөл олгосон,
- ✓ Жаргалан багийн 1-р сургуулийн хашаанд орон сууц барих зөвшөөрөл олгосон,

1.1.9 Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3<sup>3</sup>, 9.11.1<sup>4</sup>-д зааснаар Ховд аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх V жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт газар зохион байгуулалтын талаар 7 асуудлыг тусгасан ч биелэлтийг хүрсэн үр дүн, хэрэгжилттэй уялдуулан бодитой тайлагнаагүй байна.

**Аймаг, сумдын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөний биелэлт хангагдаагүй нь төлөвлөлтийг тооцоо судалгаанд үндэслээгүй, бодитой төлөвлөөгүйгээс өмнөх оны төлөвлөгөөнд үндэслэн газар олгосон байна**

1.1.10 Жил бүр аймгийн газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөг Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 20.1.2, 25.3 дахь хэсэгт заасны дагуу аймгийн ИТХ-ын тогтоолоор баталсан байна.

1.1.11 Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5<sup>5</sup>-д гэж зааснаар аймгийн хэмжээнд 2019-2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд иргэн, аж ахуйн нэгж байгууллагад 24,541.5 га газрыг эзэмшүүлэх, өмчлүүлэх, ашиглуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 1,871.5 га газрыг олгожээ.

1.1.12 Аймаг, сумдын Засаг дарга Газрын тухай хуулийн 20, 21 дүгээр зүйлд зааснаар 2019-2023 онуудын газар зохион байгуулалтын төлөвлөгөөг аймаг, сумын ИТХ-аар батлуулж, хуулийн 20.1.1<sup>6</sup> -т заасны дагуу тухайн шатны ИТХ-аар газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлтийг дүгнэсэн байна.

1.1.13 Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.1<sup>7</sup>-д заасны дагуу аймаг, сумдын ИТХ-аар газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлагдаж, биелэлт 2021 онд 93.5 хувьтай буюу хамгийн өндөр биелэлттэй байхад 2023 оны биелэлт 7.6 хувийн гүйцэтгэлтэйгээр тайлагнажээ.

Хүснэгт №1 Газар зохион байгуулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл (нэгж талбар, га)

| он      | төлөвлөгөө        |                    | гүйцэтгэл         |                    | гүйцэтгэлийн хувь |
|---------|-------------------|--------------------|-------------------|--------------------|-------------------|
|         | нэгж талбарын тоо | газрын хэмжээ (га) | нэгж талбарын тоо | газрын хэмжээ (га) |                   |
| 2019 он | 2887              | 6,764.1            | 1,166             | 5,176.3            | 76.5              |
| 2020 он | 1061              | 72,824.6           | 748               | 58,359.3           | 80.1              |
| 2021 он | 1971              | 47,597.4           | 1,191             | 44,496.6           | 93.5              |
| 2022 он | 2302              | 7,804.7            | 1,992             | 4,727.5            | 60.6              |
| 2023 он | 15857             | 24,541.5           | 5,336             | 1,871.5            | 7.6               |

Эх сурвалж нь ГХБХБГ-ын аймгийн ИТХ-д хэлэлцүүлсэн тайлан

<sup>3</sup> 5.1.3 "нэгдмэл, цогц, харилцан уялдаатай байх",

<sup>4</sup> 9.11.1 тухайн шатны Засаг даргын өргөн мэдүүлсэн Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Хөгжлийн зорилтот хөтөлбөртэй уялдсан эсэх талаар үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас ирүүлсэн саналыг харгалзан тухайн бодлогын баримт бичгийг хэлэлцэн, батлах, эсхүл буцаах.

<sup>5</sup> "Энэ хуулийн 33.1.2-т заасны дагуу төсөл шалгаруулах хэлбэрээр газар эзэмших эрхийг зөвхөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эсхүл мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх зориулалтаар малчдын хоршоонд, эсхүл гадаад улс, олон улсын байгууллагын буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрт зориулж олгоно"

<sup>6</sup> 20.1.1 газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, гаргасан шийдвэрийнхээ биелэлтэд хяналт тавих, энэ талаарх Засаг даргын тайланг хэлэлцэж дүгнэх;

<sup>7</sup> 20.2.1 "Нутаг дэвсгэртээ газрын талаар төрөөс явуулах нэгдсэн бодлого, газрын тухай хууль тогтоомж, тухайн шатны ирээдийн Төлөвлөгчдийн Хурлын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж хангах"

1.1.14 Дээрх хүснэгтээс харвал 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний гүйцэтгэл 7.6 хувийн биелэлттэй байгаагийн гол шалтгаан нь тооцоо судалгаагүйгээр аймгийн ИТХ-ын 2023 оны 11/08 дугаартай тогтоолоор “мод үржүүлгийн зориулалтаар эзэмшүүлэх” 650 га, “аялал жуулчлалын зориулалтаар эзэмшүүлэх” 68 га, “газар тариалангийн зориулалтаар эзэмшүүлэх” 20,500 га-аар тус тус нэмэгдүүлэн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулан баталсан байна.

1.1.15 Жаргалант суманд 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг үндэслэн 2023 онд газар олгосон нь Газрын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4<sup>8</sup>-д зааснаар газар зохион байгуулалтын төлөвлөгөө нь иргэн, хуулийн этгээдэд газар эзэмшүүлэх, ашиглуулах, хамгаалах, нөхөн сэргээх, байршлыг тодорхойлсон жилдээ хэрэгжүүлэх баримт бичиг байна гэснийг зөрчсөн байна.

Хүснэгт №2 Жаргалант сумын 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт

| Багийн нэр | Төлөвлөсөн                   |        | Хэрэгжилт                    |        | Зөрүү                        |        |
|------------|------------------------------|--------|------------------------------|--------|------------------------------|--------|
|            | Иргэн, хуулийн этгээдийн тоо | Хэмжээ | Иргэн, хуулийн этгээдийн тоо | Хэмжээ | Иргэн, хуулийн этгээдийн тоо | Хэмжээ |
| Цамбагарав | 4                            | 0.38   | 139                          | 10.594 | -135                         | -10.2  |
| Бичигт     | 1                            | 0.06   | 5                            | 0.4119 | -4                           | -0.35  |
| Буянт      | 5                            | 0.36   | 12                           | 0.7183 | -7                           | -0.36  |
| Бугат      | 5                            | 0.23   | 4                            | 0.257  | 1                            | -0.03  |
| Тахилт баг |                              |        | 1                            | 0.0975 | -1                           | -0.1   |

Эх сурвалж нь: Жаргалант сумын ИТХ-ын тогтоол, Засаг даргын захирамж

1.1.16 2023 онд Цамбагарав багт 135 иргэний 10.2 га, Бичигт багт 4 иргэний 0.35 га, Буянт багт 7 иргэний 0.36 га газрыг өмнөх оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг үндэслэн олгосон байна.

1.1.17 Ховд хотыг 2030 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний дагуу аймгийн ИТХ-ын 2015 оны 06 дугаар тогтоолоор Жаргалант сумын нутаг дэвсгэрт 29.2 га газар “Амины орон сууцны /хаус/ хороолол”, 2016 оны 03 дугаар тогтоолоор “Шинэ суурьшлын бүс”-ийн 15 га-д “Бичил хотхон” хороолол, 2022 оны 7/05 дугаар тогтоолоор “Шинэ суурьшлын бүс”-ийн 20 га газар барих хэсэгчилсэн төлөвлөгөө батлагдсан ч төсөл сонгон шалгаруулах журмаар олгосон нь газрын тухай хуулийн холбогдох заалттай нийцэхгүй байна. Үүнд:

- ✓ Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу олгох газрыг газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгаагүй болон төлөвлөснөөс илүү хэмжээгээр төсөл шалгаруулалтаар 14 ААН, иргэнд 10.2 га газрыг олгосон, Хавсралт №01
- ✓ Аймгийн Засаг даргын 2016 оны А/179 дугаар захирамжаар Мон лун хөгжил ХХК-д 29.2 га газрыг дуудлага худалдаа зарлалгүйгээр олгосон, газрын ашиглах эрхийн хугацааг сунгахдаа аймгийн Засаг даргын 2019 оны А/358 дугаар захирамжаар 15 га газрыг сунгаж, 14.2 га газрын ашиглах эрхийг хүчингүй болгосон, Хавсралт №01
- ✓ Шинэ суурьшлын бүсэд аймгийн Засаг даргын 2022 оны 3 дугаар сарын А/150 дугаар захирамжаар төсөл сонгон шалгаруулалтаар газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж 4.8 га газар олгох тухай захирамж гаргасан, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг 6 дугаар сард баталсан, Хавсралт №01
- ✓ Дарви суманд 2022 онд төсөл сонгон шалгаруулалтаар 0.5 га газрыг хувийн ААНБ олгосон,

<sup>8</sup> 25.4.Сум, нийслэл, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газрыг эзэмшүүлэх, ашиглуулах, хамгаалах, нөхөн сэргээх, байршлыг тодорхойлсон жилдээ хэрэгжүүлэх зураг төслийн баримт бичиг байна.

1.1.18 Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3<sup>9</sup>-д заасны дагуу тухайн шатны Засаг дарга нар иргэд, ААН байгууллагуудад газар эзэмшүүлэх, ашиглуулахдаа нутаг дэвсгэрийн хилийн цэс зөрчин суманд харьяалагдахгүй нутаг дэвсгэрт газар олгосон байна. Үүнд:

- ✓ Нисэх тосгонд Буянт сумын нутаг дэвсгэр дээр Жаргалант сумын Засаг даргын захирамжаар 30 нэгж талбарт 2.1 га газар олгосон,
- ✓ Жаргалант сумын засаг даргын захирамжаар гэр, орон сууц, хашааны зориулалтаар 48 иргэнд 3.55 га, мод үржүүлгийн зориулалтаар 8 иргэнд 7.5 га, фермерийн зориулалтаар 1 иргэнд 0.24 га газрыг Ховд сумын нутгаас олгосон,
- ✓ Булган сумын цэс зөрчин Баян-Өлгийн аймгийн Булган иргэнд 2020 оны 03 дугаар сарын 26-ны өдөр шинээр газар эзэмших гэсэн зориулалтаар бүртгэсэн,

1.1.19 Аймгийн хэмжээнд 2019-2023 онуудад газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй 17 нэгж талбарын 5.4 га газрыг олгосон нь Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3<sup>9</sup> -д заасныг зөрчсөн байна. Хавсралт №02,

1.1.20 Засаг даргын захирамжийг түүвэрлэн хянахад газрын зориулалт өөрчлөхдөө Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3<sup>9</sup> дахь заалтын дагуу тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаагүй, дуудлага худалдаа зохион байгуулаагүй олгосон байна. Тухайлбал:

- ✓ Мод үржүүлгийн зориулалттай олгосон 4 нэгж талбар 13.2 га газрыг орон сууц, гэр бүлийн, үйлдвэрийн барилга байгууламж барих зориулалт болгон өөрчилсөн,

1.1.21 Аудитын явцад газар олголттой холбоотой иргэдээс ирүүлсэн мэдээлэл, хэвлэл мэдээллээр шүүмжилж байгаа асуудлуудад үндэслэн аймгийн ГХБХБГ-ын зарим албан хаагчдын дансны хуулгыг түүвэрлэн хянахад иргэд, ААН-аас тодорхой бус мөнгө хүлээн авсан нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1<sup>10</sup>-д заасантай нийцэхгүй байж болзошгүй, төрийн албан хаагчийн орлогыг нотлох шаардлага үүссэн тул хуулийн байгууллагад шалгуулахаар шийдвэрлэв..

1.1.22 газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулахдаа судалгаа хийж үндэслэлтэй төлөвлөх, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөтэй уялдуулах, зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд тухайн шатны ИТХ-аар тодотгон батлуулах, төлөвлөгөөг мөрдөх, хяналт, хариуцлагыг сайжруулах шаардлагатай байна.

### **Иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг 53.2 хувьтай шийдвэрлэсэн, нийт хүн амын 27.8 хувь нь гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газрыг өмчилсөн байна**

1.2.1 Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш 2003 оны 05 дугаар сарын 01-ны өдрөөс 2023 оны 11 сарын байдлаар аймгийн хэмжээнд газар өмчилсөн, эзэмшсэн иргэдийн тоо 25,068 болж, нийт иргэдийн 27.8 хувь нь гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газрыг олгожээ.

Хүснэгт №3 Газар эзэмшүүлсэн, өмчлүүлсэн иргэдийн тоо

| д/д | Сумын нэр | Хүн амын тоо /2023 он/ | Газар өмчлөгч, эзэмшигч иргэдийн тоо /2023 он/ | Газар өмчлөл, эзэмшлийг хүн амын тоотой харьцуулсан хувь |
|-----|-----------|------------------------|--|--|
| 1   | Алтай     | 3,302                  | 564  | 17.1   |
| 2   | Булган    | 10,068                 | 3,211  | 31.9   |
| 3   | Буянт     | 3,686                  | 599  | 16.3   |

<sup>9</sup> 21.4.3. "Энэ хуулийн 21.3.2-т зааснаас бусад газрыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу сумын хэмжээнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг шийдвэрлэж, зохион байгуулах"

<sup>10</sup> 22.1. Албан тушаалтан өөрийн албан үүргийн дагуу авах цалин хөлснөөс гадна энэ хууль, бусад хуулиар хориглоогүй бусад ажил, алба, гэрээний урамшуулал, мөн хуулиар хориглоогүй аж ахуйн үйл ажиллагааны орлого олж болно.

|    |             |        |        |      |
|----|-------------|--------|--------|------|
| 4  | Дарви       | 2,981  | 829    | 27.8 |
| 5  | Дөргөн      | 2,872  | 429    | 14.9 |
| 6  | Дуут        | 1,787  | 500    | 28.0 |
| 7  | Зэрэг       | 3,314  | 710    | 21.4 |
| 8  | Жаргалант   | 33,680 | 10,678 | 31.7 |
| 9  | Манхан      | 4,202  | 941    | 22.4 |
| 10 | Мянгад      | 3,731  | 428    | 11.5 |
| 11 | Мөст        | 3,024  | 785    | 26.0 |
| 12 | Мөнххайрхан | 2,020  | 879    | 43.5 |
| 13 | Үенч        | 3,687  | 1,000  | 27.1 |
| 14 | Ховд        | 3,282  | 1,878  | 57.2 |
| 15 | Цэцэг       | 3,250  | 826    | 25.4 |
| 16 | Чандмань    | 2,968  | 519    | 17.5 |
| 17 | Эрдэнэбүрэн | 2,283  | 292    | 12.8 |
|    | Нийт        | 90,137 | 25,068 | 27.8 |

Эх сурвалж нь: Ховд аймгийн ГХБХБГ-аас ирүүлсэн мэдээлэл

1.2.2 Дээрх хүснэгтээс харахад Ховд, Мөнххайрхан Булган, Жаргалант сумууд иргэдэд газар олголт өндөр, Мянгад, Эрдэнэбүрэн, Чандмань сумууд бага үзүүлэлттэй байна.

1.2.3 Аймгийн хэмжээнд 2019-2023 онуудад нийт 17,458 өргөдөл ирснээс 9,280 өргөдлийг буюу 53.2 хувийг бүрэн шийдвэрлэж, 1,106 өргөдлийг шийдвэрлэхээр, 7,072 өргөдөл нь газрын төлөвлөгөөнд тусгагдаагүй, газрын маргаантай тул буцаасан байна.

Хүснэгт №4 Өргөдөл, хүсэлт шийдвэрлэсэн байдал

| он   | ирсэн  | шийдвэрлэсэн | шийдвэрлэх шатандаа | хариуг мэдэгдэхээр хуудсаар буцаасан | шийдвэрлэлтийн хувь |
|------|--------|--------------|---------------------|--------------------------------------|---------------------|
| 2019 | 2,106  | 928          | 72                  | 1,106                                | 44.1                |
| 2020 | 1,450  | 1,230        | 125                 | 95                                   | 84.8                |
| 2021 | 4,577  | 1,334        | 218                 | 3,025                                | 29.1                |
| 2022 | 2,972  | 1,992        | 427                 | 553                                  | 67.0                |
| 2023 | 6,353  | 3,796        | 264                 | 2,293                                | 59.8                |
| ДҮН  | 17,458 | 9,280        | 1,106               | 7,072                                | 53.2                |

Эх сурвалж нь: Аймгийн ГХБХБГ-ын 2019-2023 оны ИТХ-аар хэлэлцүүлсэн илтгэлээс

1.2.4 Жаргалант сум иргэдээс ирсэн өргөдлийг хүлээн авахдаа он, сар, өдөр, цаг, минутаар бүртгээгүйгээс өргөдлийг дарааллын дагуу шийдвэрлэсэн эсэх нь тодорхой бус, мөн Булган сумын Засаг даргад Их цоохор ХХК нь газрын хэмжээг өөрчлөх талаар 2020 оны 10 дугаар сарын 22-ны 08 дугаартай албан бичгээр хүсэлт уламжилсан боловч өнөөдрийг хүртэл шийдвэрлээгүй байна.

1.2.5 Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1<sup>11</sup>- д заасны дагуу 2019-2023 онуудад аймгийн хэмжээнд гэр бүлийн хэрэгцээнд өмчлүүлэх, эзэмшүүлэх зориулалтаар нийт 1,800 иргэнд 206 га газрыг эзэмшүүлж, 2,917 иргэнд 474 га газрыг өмчлүүлжээ.

Хүснэгт №5 Гэр бүлийн хэрэгцээнд 2019-2023 онуудад олгосон газар

| үзүүлэлт           | өмчлөх      |                     | эзэмшүүлэх  |                     | нийт гэр бүлийн хэрэгцээний |                     |
|--------------------|-------------|---------------------|-------------|---------------------|-----------------------------|---------------------|
|                    | Иргэний тоо | талбайн хэмжээ (га) | иргэний тоо | талбайн хэмжээ (га) | иргэний тоо                 | талбайн хэмжээ (га) |
| олгосон газрын дүн | 2,917       | 474.0               | 1,800       | 206                 | 4,717                       | 680.0               |
| Үүнээс:            |             |                     |             |                     |                             |                     |
| Булган             | 650         | 231.0               | 199         | 83.4                | 849                         | 314.4               |

<sup>11</sup> 5.1.1. газар өмчлүүлэх арга хэмжээг газар өмчлөн авахыг хүссэн иргэний сайн дурын үндсэн дээр зөвхөн энэ хуульд заасан зориулалтаар төр, олон нийтийн хяналтын дор ил тод явуулах;

|           |       |       |       |      |       |       |
|-----------|-------|-------|-------|------|-------|-------|
| Жаргалант | 1,170 | 110.4 | 1,316 | 96.8 | 2,486 | 207.2 |
|-----------|-------|-------|-------|------|-------|-------|

Эх сурвалж нь: Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газраас ирүүлсэн мэдээллийн сангийн өгөгдөл

Дээрх хүснэгтээс харвал гэр бүлийн хэрэгцээнд эзэмшүүлэх, өмчлүүлэх зориулалтаар Булган суманд 849 иргэнд 314.4 га газрыг олгосон нь өндөр үзүүлэлттэй байна.

### Зарим сумууд газартай холбоотой зөрчлийг арилгах арга хэмжээг тодорхой түвшинд хэрэгжүүлэн ажиллаж байна


1.2.6 Булган сумын ИТХ-ын 2021 оны 03 дугаар тогтоолоор сумын хэмжээнд газрын нэгдсэн тооллого, бүртгэл, судалгаа хийх газрын зөрчлийг арилгах зорилгоор ажлын хэсэг томилон ажилласны үр дүнд 1,550 га газрын торыг буулгах шийдвэр гарган 80 гаруй хувьтай хэрэгжүүлэн 3,100 гаруй нэгж талбарын мэдээллийг мэдээллийн санд оруулж, 2021-2024 онуудад 584 гаруй иргэн айл өрхүүдэд газар олгосон нь бусад сумууд хэрэгжүүлэх сайн туршлага бий болжээ.

1.2.7 Мөн Чандмань, Мөст сумдад зөвшөөрөлгүй бэлчээр болон хадлангийн талбай торлож ашиглаж байсан 18 торыг албадан буулган 41.4 га газрыг чөлөөлөх арга хэмжээг авч ажилласан байна.

1.2.8 Гэр бүлийн зориулалтаар газар хүссэн иргэдийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор 2023 онд Ховд сумын Баянбулаг багийн ИНХ-д 5,000 иргэний 350 га газрыг шийдвэрлүүлэх саналыг хэлэлцүүлэн сумын ИТХ-аар батлуулан газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулан хэрэгжүүлсэн нь газар хүссэн иргэдийн өргөдөл, хүсэлтийг хангасан, тулгамдсан асуудлыг шийдвэрлэсэн нь үр дүнтэй ажил болжээ.

1.2.9 Жаргалант сумын хэмжээнд 2019-2023 онуудад зөвшөөрөлгүй дур мэдэн хашаа татсан, объект барьсан, зөвшөөрөгдсөн хэмжээнээс хашаагаа илүү татсан иргэн, ААНБ-ын нийт 34.93 га газрыг чөлөөлөх арга хэмжээг авч ажиллажээ.

чөлөөлсөн газрын хэмжээ /га/ График




■ 2019 он ■ 2020 он ■ 2021 он ■ 2022 он ■ 2023 он

1.2.10 Газар олголттой холбоотой дээрх үр дүнтэй ажил хэрэгжүүлэн ажиллаж байгаа ч дараах нийтлэг зөрчил арилахгүй байна.

- ✓ Жаргалант сум 2022 онд Цэргийн ангийн бэлтгэлийн талбайн газарт давхцуулан 8 гудамжны 160 айлын 12.2 га газар олгосон,
- ✓ Жаргалант сум ундны усны хамгаалалтын зурваст иргэнд газар олгосон,
- ✓ Булган сумын Бүрэнхайрхан багийн иргэн нь 2024 онд үл хөдлөх эд хөрөнгө худалдах, худалдан авах (Өмчлөлийн газар) гэрээгээр 12.0 сая төгрөгөөр иргэнд 1000 м<sup>2</sup> газрыг худалдсан боловч мөнгийг сумын газрын даамлын нөхрийн дансаар 8.0 сая төгрөгийг авсан,
- ✓ Булган сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаагүй А/97 дугаартай захирамжаар 0.8 га газрыг хийдийн зориулалтаар олгосон,


1.2.11 Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар эзэмшүүлэх, өмчлүүлэх талаар захирамжгүй Буянт сумын газар олголттой холбоотой 2024 оны орон нутгийн сонгуулийн өмнө Норжин хайрхан багт буюу Нисэх буудлын ойролцоо иргэдэд “газар олгох зөвшөөрлийн бичиг” тараасан талаар Ховд.mn цахим сайтаар мэдээлэл цацагдсан асуудал хуулийн байгууллагад шалгагдаж байна.

Зураг 1. Буянт сумаас иргэдэд тараасан газар олгох эрхийн бичиг



**Гэр, орон сууц, хашааны зориулалтаас бусад зориулалтаар газрыг олгохдоо дуудлага худалдаа зохион байгуулаагүйгээс 322.0 сая төгрөгийн орлого бүрдэх боломжийг алдсан байна**

1.2.12 Аймгийн хэмжээнд 2019-2023 онуудад гэр, орон сууц, хашааны газраас бусад ойжуулах, мод үржүүлэг, газар тариалан, өвөлжөө, хаваржаа, хөдөө аж ахуй, худалдаа үйлчилгээний зориулалтаар олгосон газраас 3,977 нэгж талбарын 26,282.8 га газрыг цахим мэдээллийн санд бүртгэсэн байна.



Эх сурвалж нь: Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газраас ирүүлсэн мэдээллийн сангийн өгөгдөл

1.2.13 Графикаас үзэхэд хамгийн өндөр үзүүлэлттэй Дөргөн 13,020 га газрыг тэжээлийн ургамал тариалахтай холбоотой олгосон нь нөлөөлсөн бол хамгийн бага Дуут сум 28.8, Чандмань сум 36.3, Мөст сум 59.5 га газрыг мэдээллийн санд оруулжээ.

1.2.14 Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2<sup>12</sup>-д гэж заалтыг зөрчин хуульд заасан хэмжээнээс илүү газар эзэмшиж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад дуудлага худалдаа зохион байгуулалгүйгээр газар олгож байна. Тухайлбал:

- ✓ Аймагт газрын зохион байгуулалтын төлөвлөгөөнд хөдөө аж ахуй, мод үржүүлэг, аялал жуулчлал, тэжээлийн ургамал, жимс, жимсгэнэ, фермерийн зориулалтаар хуулиар зөвшөөрсөн хэмжээнээс илүү хэмжээгээр газар олгохдоо дуудлага худалдаа зохион байгуулаагүй 211 иргэн, ААН байгууллагуудад 14,053.1 га газар олгосонд албан шаардлага өгөх,
- ✓ Жаргалант суманд үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар газрыг олгохдоо зарим нэгж талбарын хувьд дуудлага худалдаа зохион байгуулаагүйгээс 27 иргэнд 24.03 га газрыг олгож 288.0 сая төгрөгийн орлого бүрдүүлэх боломж алдсан асуудлыг хуулийн байгууллагад шилжүүлэх Хавсралт №06

<sup>12</sup> "энэ хуулийн 33.1.1-д зааснаас бусад зориулалтаар болон энэ хуулийн 29.1, 29.2, 29.3-т заасан хэмжээнээс илүү газар эзэмших хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх зориулалтаар малчдын хоршоонд нэг удаа 5 га хүртэлх газар эзэмшүүлэх асуудлыг аймаг, сум, нийслэлийн Засаг дарга дуудлага худалдаа, төсөл шалгаруулах зарчмаар шийдвэрлэнэ. Төсөл шалгаруулах, дуудлага худалдаа явуулах журмыг Засгийн газар тогтооно."

- ✓ Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар Цэцэг суманд олгох газруудад дуудлага худалдаа зохион байгуулалгүйгээр 4 нэгж талбар, 34.0 сая төгрөгийн үнэлгээтэй 4.25 га газар олгосон тул албан шаардлага өгөх,
- ✓ Булган сумын 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд дуудлага худалдаагаар эзэмшүүлэх баталсан 100 м<sup>2</sup> га газрыг иргэний өргөдөл гомдлыг үндэслэн сумын ИТХ-ын 2022 оны 06 дугаар сарын 14 –ний 05 тогтоолоор хүчингүй болгосон,

**Төрийн байгууллагуудын эзэмшлийн газрыг хуулийн холбогдох заалтыг зөрчин бусдад эзэмшүүлсэн зөрчлийг арилгах зорилгоор газар эзэмших зөвшөөрлийг хүчингүй болгосон ч газрыг чөлөөлөөгүй үргэлжлүүлэн эзэмшиж, ашиглаж байна**

1.2.15 Булган сумын Засаг даргын 2023 оны А/39 дугаартай захирамжаар Минжит Булган хот тохижилт ОНӨААТҮГ-т 12 га газар эзэмшүүлсэн, А/102 дугаартай захирамжаар Байтаг багийн матгарын хөдөөд байрлах 12 га газрыг Минж булагт арвижих майнинг ХХК-д гаалийн хяналтын талбайн зориулалтаар эзэмших эрхийг шилжүүлсэн нь Газрын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2<sup>13</sup>, Засгийн газрын 2020 оны 10 дугаар тогтоолын 7<sup>14</sup> дахь заалтуудыг зөрчжээ.

1.2.16 Авто тээврийн Үндэсний төвийн харьяа Ховд салбарт Жаргалант сумын Засаг даргын 2016 оны А/158 дугаар захирамжаар 5.6 га газар эзэмших эрх олгосон ч тус газарт "Ховд зорчигч тээвэр" ХХК-д давхцуулан 3 га газар олгож авто тээврийн үйлчилгээний барилга барьсан байна.

1.2.17 Гэр, орон сууц, хашааны зориулалтаас бусад зориулалтаар газар олгогдсон зөрчилтэй асуудлууд хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шаллагдаж байна. Үүнд:

- Булган сумын Их цоохор нуур ХХК-ын 40 га газартай холбоотой асуудлаар АТГ-т шаллагдаж байгаа,
- Булган сумын Засаг даргын А/97 дугаартай захирамжаар 8644 м<sup>2</sup> газрыг Гэндэншаддүвдамбадэлжайлин хийдэд эзэмшүүлэхээр олгосон, 2023 оны А/7 дугаартай захирамжаар хүчингүй болгосон асуудал хууль хяналтын байгууллагад шаллагдаж байгаа,
- Ховд аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх 457 дугаар ангийн эзэмшлийн 30 га газрын кадастрын зургийг өөрчлөн Номин реалтор ХХК-д үйлчилгээний зориулалтаар эзэмшүүлсэн асуудлыг хуульд шалгуулахаар хүргүүлсэн,

1.2.18 Жаргалант сумын Шинэ суурьшлын бүсэд 12 аж ахуйн нэгж, 1 иргэний 22.75 га газрыг аймгийн Засаг даргын 2023 оны А/410 тоот захирамжаар хуулийн хугацаанд төлбөрөө төлөөгүй, 2 жилээс дээш хугацаанд газраа зориулалтын дагуу ашиглаагүй гэсэн үндэслэлээр хүчингүй болгосон асуудлаар эзэмшигч иргэн, ААНБ-ууд хуулийн байгууллагад гомдол гарган шаллагдаж "Мон лун төсөл" ХХК-ний 15 га, "Зөөлөн тэмүүлэл" ХХК-ний 1.2 га, "Богоч констракшн" ХХК-ний 0.6 га газрууд нь дээд шүүхээс тухайн газар эзэмшигчийн талд шийдвэрлэсэн, иргэн А-тай эвлэрлийн гэрээ байгуулж бусад ААНБ-ийн гомдол шийдвэрлэгдээгүй байна.

1.2.19 Газрын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4-д "Хүчин төгөлдөр эрхийн гэрчилгээгүй аливаа этгээд газар эзэмшихийг хориглоно" гэсэн заалтыг зөрчин газар эзэмших зөвшөөрөлгүй газар дээр барилга байгууламж барьсан байна. Тухайлбал:

- ✓ Бадамлах дөл ХХК дулааны шугамын газрыг эзэмших зөвшөөрөл аваагүй, газрын төлбөр төлдөггүй, дулааны шугам дээр /10 байршилд/ дулаан дамжуулах төв барьж ашигласан,

<sup>13</sup> 35.2.Энэ хуулийн 35.1.4, 35.1.6-д заасан эрх төрийн байгууллагад хамаарахгүй.


<sup>14</sup> Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эзэмшилд байгаа барилга байгууламжийн доорх газар эзэмших, ашиглах эрхийг иргэн, хувийн хэвшлийн хуулийн этгээдийн нэр дээр олгосныг цуцалж, тухайн төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн нэр дээр баталгаажуулах, газар эзэмшилтэй холбоотой зөрчлийг арилгах арга хэмжээг 2020 онд багтаан авч хэрэгжүүлэх, цаашид төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд эзэмшүүлсэн газраас хувийн хэвшлийн хуулийн этгээд, иргэнд эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр гаргахгүй байх, барилга барих, эхлүүлэх зөвшөөрөл олгохгүй байхыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

- ✓ Ховд Дулааны станц ТӨХК-ний дулааны шугамын газрыг эзэмших зөвшөөрөл аваагүй, газрын төлбөр төлдөггүй, дулааны шугам дээр /17 байршилд/ дулаан дамжуулах төв барьж ашигласан,

1.2.20 Аймгийн хэмжээнд 186 иргэн 973.3 га газрыг зөвшөөрөлгүй ашиглаж байгаа нь Газрын тухай хуулийн хэрэгжилтэд тавих төрийн байгууллагуудын хяналт сул байгаа зөрчилд албан шаардлага өглөө.

1.2.21 Мөн 24 иргэн, аж ахуйн нэгж 245.9 га газрыг зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашиглаж байгаа зөрчилд албан шаардлага өглөө. Тухайлбал: Бадамлах дөл ХХК дулааны станцын гаднах хамгаалалтын хашааг 1100 метр квадрат сунгаж ашигласан,

Зураг 2. Зөвшөөрөлгүй олгосон газрын зураг



1.2.22 Газар эзэмших захирамж хүчингүй болгож эрхийг түдгэлзүүлсэн байхад газар эзэмшиж, ашигласаар байна.

- ✓ Буянт сумын Засаг даргын 2022 оны А/26 дугаар захирамжаар иргэн Б-гийн Бугат үзүүрийн баруун талд аялал жуулчлалын зориулалтаар 3 га, ойжуулалт, тохижуулалтын зориулалтаар 17 га олгосныг 2022 оны А/65 дугаар захирамжаар;
- ✓ Буянт сумын Засаг даргын 2016 оны А/29 дүгээр захирамжаар Ховд Агро парк ХХК-д “агро парк” байгуулах зориулалтаар 1900 га олгосныг 2018 оны А/106 дугаар захирамжаар хүчингүй болгосон байхад 2022 онд хүчингүй захирамжаар цахим мэдээллийн санд оруулсан,
- ✓ Дарви суманд 8401001339 нэгж талбарын дугаартай 0.06 га газрыг хүчингүй болгосон ч газрын мэдээллийн санд засварлаагүй,
- ✓ Жаргалант сумын Засаг дарга 2023 оны А/58 дугаартай захирамжаар Мэдээлэл холбоо сүлжээ ТӨХК-д шилэн кабель суурилуулах зориулалтаар газар олгохдоо газрын хэмжээг заагаагүй,
- ✓ Жаргалант сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаагүй 2023 оны А/274 дүгээр захирамжаар 0.1 га газрыг түр ашиглуулах зориулалтаар олгохдоо хугацаа заагаагүй, ашиглуулах гэрээ байгуулаагүй,

1.2.23 2023 оны санхүүгийн тайланг баталгаажуулах аудитаар төрийн байгууллагын эзэмшиж байгаа газрыг нягтлан бодох бүртгэлд тусгахдаа хэмжээ болон үнэлгээг зөрүүтэй тусгасан, зарим төрийн байгууллагууд эзэмшиж буй газраа бүртгэлд тусгаагүй, балансад бүртгэлтэй газар нь газрын гэрчилгээгүй, кадастрын зураггүй, кадастрын зургийг өөрчилсөн зэрэг зөрчлүүдийг санхүүгийн тайланд залруулга хийж, зөвлөмж өгч хэрэгжилтийг хангуулж ажиллалаа.

1.2.24 Дээрх алдаа зөрчлүүдээс үзэхэд газар олголттой холбоотой зөрчлүүдийг бүрэн арилгах, албан хаагчдын ажлын хариуцлагыг сайжруулах, Газрын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах шаардлагатай байна.

## БҮЛЭГ 2 ГАЗРЫН ТӨЛБӨРИЙН ОРЛОГЫГ БҮРЭН НОГДУУЛААГҮЙ, ГАЗРЫН ТӨЛБӨРИЙН БҮРДҮҮЛЭЛТЭД ТАВИХ ХЯНАЛТЫГ ҮР НӨЛӨӨТЭЙ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА

**Газрын төлбөрийн орлогыг дутуу ногдуулснаас 406.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлэх боломж алдсан байна**

2.1.1 Газрын тухай хуулийн 7 дугаар зүйл, Газрын төлбөрийн тухай хууль болон Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2018 оны А/187, 2022 оны А/209 дүгээр тушаалаар баталсан “газрын төлбөр ногдуулах аргачилсан заавар”-ыг баримтлан газрын төлбөрийн ногдуулалтыг хийж байна.

Хүснэгт №6

Газрын төлбөрийн ногдуулалт 2019-2023 он

| д/д | Сумдын нэр  | 2020  | 2021  | 2022  | 2023    | ДҮН     |
|-----|-------------|-------|-------|-------|---------|---------|
| 1   | Алтай       | 0.8   | 1.3   | 1.7   | 2.1     | 6.0     |
| 2   | Булган      | 3.8   | 10.1  | 28.9  | 43.3    | 86.2    |
| 3   | Буянт       | 24.6  | 25.7  | 28.1  | 64.6    | 143.0   |
| 4   | Дуут        | 1.1   | 2.7   | 6.0   | 7.3     | 17.0    |
| 5   | Дарви       | 221.5 | 224.8 | 326.9 | 314.0   | 1,087.3 |
| 6   | Дөргөн      | 4.1   | 4.2   | 8.9   | 17.3    | 34.4    |
| 7   | Зэрэг       | 1.8   | 2.1   | 2.3   | 5.1     | 11.3    |
| 8   | Манхан      | 2.5   | 4.2   | 13.8  | 26.2    | 46.7    |
| 9   | Мөнххайрхан | 2.9   | 4.1   | 7.4   | 6.5     | 21.0    |
| 10  | Мөст        | 1.4   | 1.7   | 5.2   | 5.6     | 13.9    |
| 11  | Мянгад      | 7.1   | 6.9   | 15.7  | 18.1    | 47.8    |
| 12  | Ховд        | 2.3   | 4.7   | 10.7  | 16.6    | 34.3    |
| 13  | Цэцэг       | 7.6   | 9.8   | 16.1  | 17.3    | 50.8    |
| 14  | Үенч        | 10.2  | 10.3  | 16.8  | 26.8    | 64.1    |
| 15  | Чандмань    | 0.6   | 0.7   | 7.2   | 8.4     | 16.8    |
| 16  | Эрдэнэбүрэн | 0.4   | 0.6   | 4.1   | 4.8     | 9.9     |
| 17  | Жаргалант   | 103.3 | 112.5 | 480.6 | 688.6   | 1,385.0 |
|     | НИЙТ ДҮН    | 396.2 | 426.4 | 980.4 | 1,272.7 | 3,075.6 |

Эх сурвалж нь: Аймгийн ГХБХБГ-ын төлбөрийн мэргэжилтнээс ирүүлсэн мэдээлэл

2.1.2 Дээрх хүснэгтээс харахад 2020 онд 396.2 сая төгрөгийн орлого ноогдуулж байсан бол 2023 онд 1,272.7 сая төгрөг болж 3.2 дахин нэмэгдсэн нь цахимаар газрын төлбөрийг ноогдуулж татварын бааз нэмэгдсэн, нөхөн бүрдүүлэлт хийсэн зэрэгтэй холбоотой байна

2.1.3 Газрын төлбөрийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2<sup>15</sup>, Газрын төлбөрийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4<sup>16</sup>, Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолын 7 дугаар хавсралт, аймгийн ИТХ-ын 2021 оны 5/08 дугаар тогтоолын хавсралтад аймгийн нутаг дэвсгэрт олон улсын болон орон нутгийн чанартай, аж ахуйн нэгж байгууллагын дотоодын зам, мэдээлэл холбооны шугам сүлжээ, эрчим хүчний шугам сүлжээ, дулаан цэвэр бохир усны шугам сүлжээний газрын төлбөрийн итгэлцүүрээр ногдуулахаар заасан ч 21.2 сая төгрөгийн газрын төлбөр ногдуулаагүй байна. *Хавсралт №07*

2.1.4 Газрын төлбөрийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4<sup>17</sup>-д заасны дагуу ашигт малтмал, газрын тосны газраас гаргасан судалгаагаар Ховд аймагт 32,443 га газарт 38 ашиглалтын тусгай зөвшөөрөл олгогдсон газарт газрын төлбөрийг ноогдуулж орон нутгийн орлогыг нэмэгдүүлэх боломжтой байна.

<sup>15</sup> 6.1.2 “Газрын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан зам, шугам сүлжээний газрын километр тутмаас”

<sup>16</sup> 7.1.4 зам, шугам сүлжээний газрын километр тутмын газрын төлбөрийн доод хязгаар 1500 төгрөг, дээд хязгаар 7500 төгрөг;

<sup>17</sup> 7.4 “Уурхайн эдэлбэрийн ашиглалт явуулж байгаа хэсэгт зохих хууль тогтоомж, гэрээний дагуу үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газрын төлбөрийг ойр орших улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын бүсэд хамааруулан хоёр дахин өсгөж тооцно”

- ✓ Буянт сумын нутаг дэвсгэрт Вестерн холд ХХК-д шохойн 143.8 га газарт ашиглалтын тусгай зөвшөөрөл гарсан бөгөөд 2023 оны байдлаар уулын ажилд 7.8 га талбайг ашигласан байхад газрын мэдээллийн системд ороогүй,
- ✓ Дарви суманд уул уурхайн ашиглалт явуулж буй Мо Эн Ко ХХК, Тефис майнинг ХХК-ийн газрын төлбөрийн ногдуулалтыг 406.9 сая төгрөгөөр дутуу тооцсон,

2.1.5 Иргэн ААН байгууллагуудын нэгж талбар талбайн хэмжээг цахим мэдээллийн санд бүрэн оруулаагүй, газрын гэрчилгээг шинэчлээгүй, улсын бүртгэлийн е дугааргүй газар эзэмшигч, ашиглагчийн газрын төлбөрийн ногдуулалтыг бүрэн тооцож чадахгүй орхигдох эрсдэл үүссэн байна.

**2019-2023 онуудад 2,487.0 сая төгрөгийн газрын төлбөрийн орлого бүрдүүлж, газар эзэмших, ашиглах эрхээ бусдад шилжүүлэхдээ эрх борлуулсны орлогод татвар ногдуулаагүй байна**

2.1.6 Газрын төлбөрийн тухай хуульд газрыг эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагууд газрын төлбөрийг төлөхөөр хуульчилсны дагуу аймгийн хэмжээнд 2019 онд 215.0 сая төгрөг байсан бол 2023 онд 742.3 сая төгрөгөөр баталж өмнөх оноос 527.3 сая төгрөгөөр газрын төлбөрийн орлогыг нэмэгдүүлэн төлөвлөн баталжээ.


Хүснэгт №7 Газрын төлбөрийн 2019-2023 оны орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая.төгрөг/

| Сумдын нэрс | 2020 он        |               | 2021 он        |               | 2022 он        |               | 2023 он        |               |
|-------------|----------------|---------------|----------------|---------------|----------------|---------------|----------------|---------------|
|             | Төлөвлө<br>гөө | Гүйцэт<br>гэл | Төлөвлө<br>гөө | Гүйцэт<br>гэл | Төлөвлө<br>гөө | Гүйцэт<br>гэл | Төлөвлө<br>гөө | Гүйцэт<br>гэл |
| Ховд шууд   | 220            | 99.7          | 204.4          | 116.8         | -              | 167.1         | -              | 20.9          |
| Алтай       | -              | 0.01          | 0.1            | 0.6           | 1.3            | 1.5           | 5.3            | 1.3           |
| Булган      | -              | 0.5           | 1.1            | 1.2           | 35.4           | 11.4          | 43.1           | 22.2          |
| Буянт       | -              | 0.00          | 9.3            | 1.3           | 25.7           | 22.7          | 27.6           | 26.9          |
| Дарви       | -              | 0.8           | 86.2           | 0.7           | 222.2          | 359.8         | 210.5          | 245.8         |
| Дуут        | -              | 0.1           | 0.3            | 0.4           | 2.7            | 2.0           | 6.2            | 3.0           |
| Зэрэг       | -              | 0.6           | 2.0            | 1.2           | 2.0            | 1.0           | 5.0            | 4.0           |
| Манхан      | -              | 0.7           | 0.6            | 1.7           | 3.9            | 3.6           | 11.7           | 9.4           |
| Дөргөн      | -              | 1.5           | 1.7            | 1.6           | 4.2            | 5.8           | 7.4            | 14.1          |
| Мянгад      | -              | 2.1           | 0.9            | 4.2           | 9.9            | 11.0          | 15.6           | 13.1          |
| Мөнххайрхан | -              | 0.4           | 0.3            | 0.8           | 4.3            | 2.8           | 5.5            | 4.1           |
| Үенч        | -              | 11.3          | 6.4            | 5.4           | 23.5           | 93.7          | 15.6           | 246.9         |
| Чандмань    | -              | 1.0           | 0.2            | 0.4           | 0.8            | 4.7           | 4.5            | 5.4           |
| Эрдэнэбүрэн | -              | 0.1           | 0.1            | 0.1           | 1.4            | 3.1           | 5.4            | 1.3           |
| Жаргалант   | -              | 30.0          | 36.9           | 48.3          | 138.7          | 209.6         | 345.8          | 391.8         |
| Мөст        | -              | 0.3           | 0.5            | 0.2           | 1.7            | 2.2           | 5.2            | 4.2           |
| Цэцэг       | -              | 1.8           | 1.8            | 3.5           | 11.7           | 10.9          | 14.8           | 9.6           |
| Ховд сум    | -              | 0.2           | 0.6            | 0.4           | 4.8            | 2.9           | 13.1           | 13.2          |
| Нийт        | 220            | 151.0         | 353.3          | 188.9         | 494.3          | 915.8         | 742.3          | 1,037.1       |

Эх сурвалж нь: Ховд аймгийн ТЕЗ-ийн 2019-2023 оны санхүүгийн тайлан

2.1.7 Газрын төлбөрийн орлогыг 2019 онд 194.2 сая төгрөгийг аймгийн төсөвт, 2021-2023 онуудад 2,292.8 сая төгрөгийг аймаг, сумын төсөвт төвлөрүүлж, 2019-2023 онуудад газрын төлбөрийн орлого 53.4-185.2 хувьтай биелүүлсэн байна.


Газрын төлбөрийн орлогын биелэлт /хувиар/ График №3



2.1.8 Газрын дуудлага худалдааны орлогыг 2020 онд 110.0 сая төгрөгөөр аймгийн хэмжээнд нэгтгэн төлөвлөж байсан бол 2023 онд Булган сум 30.0, Цэцэг сум 107.0, Жаргалант сум 397.0 сая төгрөгөөр нийт 534.2 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээр төлөвлөн баталжээ.

2.1.9 Дуудлага худалдааны орлогыг 2019-2023 онуудад аймгийн хэмжээнд нийт 1,217.2 сая төгрөгөөр төлөвлөн батлагдаж гүйцэтгэлээр 646.0 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн, Булган сум 2021 онд газрын дуудлага худалдаа зохион байгуулан 10.6 сая төгрөгийн орлого бүрдүүлэн сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлэн дараа онд зарцуулжээ.

Эх сурвалж нь: Ховд аймгийн ТЕЗ-ийн 2019-2023 оны санхүүгийн тайлан



2.1.10 2023 онд газрын дуудлага худалдааны орлогыг Булган, Цэцэг, Жаргалант сум 30-397.0 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээр батлагдаж, гүйцэтгэл 68.1 хувь буюу 363.8 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн, төлөвлөгөөнд тусгагдаагүй Алтай, Дуут, Зэрэг, Мөнххайрхан, Манхан, Дөргөн сумдад 3.3-13.0 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

2.1.11 Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.6<sup>18</sup>, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2<sup>19</sup>, хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2<sup>20</sup>- д заасны дагуу газар эзэмших, ашиглах эрхээ бусдад шилжүүлсэн тохиолдолд эрх борлуулсны орлогын албан татвар ногдуулаагүй байна.

- ✓ Жаргалант суманд 3000м<sup>2</sup> дээш хэмжээтэй газар эзэмших эрхээ бусдад шилжүүлсний орлогын албан татвар төлөлтийг түүвэрлэн авч үзэхэд 2020 онд 17 эрх шилжүүлэлтээс 169.7 сая, 2021 онд 20 эрх шилжүүлэлтээс 132.1 сая төгрөг,
- ✓ Цэцэг, Ховд, Үенч сумуудад түүвэрлэн үзэхэд 2.4 сая төгрөгийн татварыг ногдуулаагүй,

<sup>18</sup> 38.6 "Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлсэн бол орлого олсон гэж үзэж, орлогын хэмжээг дуудлага худалдааны анхны үнээс багаагүй байхаар тооцно"

<sup>19</sup> 30.2.Эцсийн эзэмшигчийн эзэмшиж байгаа хувьцаа, хувь оролцоо, саналын эрхийг борлуулах, шилжүүлэх замаар Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу олгосон газар эзэмших, ашиглах эрх, ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг бүрэн буюу хэсэгчлэн борлуулах, шилжүүлэхтэй холбогдон олсон орлогыг тухайн эрх эзэмшигч аж ахуйн нэгжийн энэ хуулийн 10.1.2-т заасан орлогод тооцно.

<sup>20</sup> 10.1.2.газар эзэмших, ашиглах эрх болон бусад биет бус хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлого;

**Газар олголт, газрын төлбөрийн орлогын бүрдүүлэлт ногдуулалтад аймаг, сумдын ИТХ болон Засаг дарга нар хуульд заасны дагуу хяналт хэрэгжүүлээгүй, өмнөх аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилт хангадаагүй, албан хаагчдын ажлын хариуцлага сул байна**

2.2.1 Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас 2022 онд хийгдсэн хяналт шинжилгээ үнэлгээгээр Засгийн газрын 2020 оны 384 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах хүрээнд бүх шатны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг газрын удирдлагын цахим системд оруулж баталгаажуулан хэрэгжилтэд хяналт тавих, 2021, 2022 оны төлөвлөгөөнд тусгагдаагүй байршилд олгосон захирамжийг хянаж, зөрчлийг арилгах, газрын тухай хуульд заасан газар ашиглалтын зориулалт, хэмжээ, эрхийн төрлийг зөрчиж газар олгохгүй байх зэрэг зөвлөмжүүд өгсөн байна.

2.2.2 Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.<sup>21</sup> дэх заалтад заасны дагуу аймаг, сумдын ИТХ-аар тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө, биелэлтийг жил бүр хэлэлцэн баталж байгаа ч төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар хяналт шалгалт хийгдсэн эсэх нь тодорхой бус баримт материал ирүүлээгүй.

2.2.3 Газрын тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 “Газрын нэгдмэл санг эзэмших, ашиглах, хамгаалах болон газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд ..., аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга хууль тогтоомжид заасан эрх хэмжээнийхээ дагуу хяналт тавина” гэж заасан ч 2019 -2023 онуудад аймаг, сумын ИТХ, Засаг дарга нар хяналт тавьж ажилласан талаар тайлан мэдээлэл ирүүлээгүй.

2.2.4 Аймгийн ГХБХБГ-аас 2019-2023 онуудад газрын төлбөрийн орлогын ногдуулалт, төлөвлөлтөд хяналт тавих талаар 2021 оны байгууллагын даргын албан бичгээр сумдад хүргүүлсэн, Булган суманд газрын тооллого бүртгэл хийх, газрын сангийн мэдээллийг бүрдүүлэх, зөрчлийг арилгах асуудлаар 2021 оны 2 дугаар сард ажилласан ч, сумдад хяналт шалгалтыг хийх удирдамж, тайлангүй байгаа нь хяналтын үр нөлөө бий болоогүй байна.

2.2.5 ГХБХБГ-аас аймгийн хэмжээний нийт газар эзэмшигчдийн тоо, газрын хэмжээтэй холбоотой мэдээлэл, хяналт хэрэгжүүлсэн талаар тайлан болон бусад баримт материалыг ирүүлээгүйгээс газрын төлбөрийн орлогыг бүрэн ногдуулсан эсэхийг тодорхойлох боломжгүй тул аудитаар түүвэрлэн хянасан асуудлуудын хүрээнд судалгаа гаргаж, дүгнэлт өглөө.

2.2.6 Газар олголтод хийж буй төрийн байгууллагын хяналт сул байгаагаас газрыг зориулалтын дагуу ашиглахгүй 30 иргэн ААН-ийн ашиглаж байгаа 21.2 га газрын гэрээ дүгнээгүй зөрчил нийтлэг гарч байгаа тул албан шаардлага өглөө.

**Газрын мэдээллийн системд 22,556 нэгж талбарын мэдээллийг оруулж хэрэгжилт 85.8 хувьтай байна**

2.2.7 Газрын мэдээллийн системийг 2016 оноос нэвтрүүлж эхэлсэн бөгөөд уг системээс хаягийн мэдээллийн систем, газар зохион байгуулалт төлөвлөлтийн цахим систем, газрын кадастрын систем, газрын үнэлгээний систем зэрэг 4 үндсэн дэд системүүдийг өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж байна.

2.2.8 Улсын хэмжээнд нийслэл, 21 аймаг, бүх сум, дүүргийг хамарсан, бусад газрын харилцаатай холбогдох байгууллагуудтай холбогдсон Газрын кадастрын мэдээллийн сангийн “Лэнд менежер” программ хангамжид суурилсан газрын кадастрын мэдээллийн санг холбосон мэдээлэл дамжуулах сүлжээ болон газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийн нэгдсэн нэг стандарттай мэдээлэл бүхий системийг бий болгосон байна.

<sup>21</sup> 20.1.1. газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, гаргасан шийдвэрийнхээ биелэлтэд хяналт тавих, энэ талаарх Засаг даргын тайланг хэлэлцэж дүгнэх;

2.2.9 Газрын кадастрын мэдээллийн сангийн “Лэнд менежер” программ хангамж нь нийт 40 гаруй төрлийн өргөдлийг хүлээн авч шийдвэрлэх, 60 гаруй төрлийн тайлан мэдээ гарах, 15 төрлийн хяналт шалгалтыг автоматаар хийх боломж бүхий мэдээллийн сангийн программ хангамж юм.

2.2.10 Ховд аймгийн хэмжээнд нийт 25,989 нэгж талбар байгаагаас 22,556 нэгж талбарын мэдээллийг оруулсан нь 85.8 хувийн мэдээллийг мэдээллийн санд оруулжээ.

2.2.11 Газрын мэдээллийн санд сумдын газрын даамлууд газар эзэмшигч, ашиглагчийн нэгж талбар, зориулалт, хугацаа зэрэг мэдээллийг зөрүүтэй оруулсан, хувийн хэргийг хангалтгүй бүрдүүлсэн, аудитад шаардлагатай судалгааг бүрэн гаргаж ирүүлээгүй зөрчил нийтлэг байна. Үүнд:

- ✓ Булган сумын газрын даамал 8 нэгж талбарын 81.4 га газрын зориулалт зөрүүтэй, 10 нэгж талбарын 54.1 га-гаар захирамжид заасан хэмжээнээс зөрүүтэй, 6 нэгж талбарын газар эзэмших жилийг захирамжид заасан хугацаанаас 15 жилээр илүү оруулсан,
- ✓ Булган сумын газрын даамал сумын засаг даргын захирамжаар баталгаажаагүй өөрийн ээжид 2511 м2 олгосон,
- ✓ Цэцэг, Дарви, Жаргалант, Алтай сумдын газрын даамлууд мэдээллийн системд нэгж талбарын хэмжээ, захирамж, зориулалтын мэдээллийг зөрүүтэй оруулсан,
- ✓ Жаргалант сумын нэгж талбарын хувийн хэргийн бүрдүүлэлт хангалтгүй, архивын нэгж болгоогүй, даамлын өрөөнд хадгалалт хангалтгүй эмх цэгцгүй,
- ✓ Жаргалант сум 2023 онд газар олгох захирамж гаргахдаа А/350, А/352-А/356 хүртэлх дугаарыг давхардуулан гаргасан,
- ✓ Алтай сумын газрын даамал холбогдох судалгааг ирүүлээгүй,
- ✓ Булган сумын газрын даамал судалгаа бүрэн гаргаж ирүүлээгүй,
- ✓ ГХБХБГ нь газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлтийг сум бүрээр нэгтгэн гаргаагүй, газрын нэгдсэн мэдээ тайлан гаргалт хангалтгүй, албан хаагчдын ажлын уялдаа холбоогүй, тоо мэдээлэл зөрүүтэй, ажлын хариуцлага хангалтгүй,

**Өмнөх аудитын шийдвэрийн хэрэгжилт бүрэн хангагдаагүй, албан хаагчдын ажлын хариуцлага сул байна**

2.2.12 Өмнөх нийцлийн аудитаар зөвшөөрөлгүй газраа сунгасан, дуудлага худалдаа явуулахгүйгээр үйлдвэр үйлчилгээний зориулалттай газар олгосон, зориулалтын дагуу ашиглаагүй, тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй, 2 жилийн хуулийн хугацаа хэтэрсэн, дуудлага худалдаагаар ялалт байгуулсан 2 иргэнд газрын гэрчилгээ олгоогүй, газрын дуудлага худалдааны орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлээгүй, зориулалт бусаар зарцуулсан зэрэг зөрчил холбоотой 42.1 сая төгрөгийн 2 төлбөрийн акт, 19 албан шаардлага, 20 зөвлөмж өгөгдсөн байна.

Хүснэгт №8

Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмж

| ИТХ-ын даргад  | Аймгийн засаг дарга, сумдын засаг дарга нарт   | Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргад  |
|--|--|---|
| Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хийж, батлуулан мөрдөж ажиллах             | Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй газарт захирамж гарган газар эзэмшүүлэхийг таслан зогсоох  | Аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан сумдын газар зохион байгуулалтын төлөвлөгөөг мөрдүүлж ажиллах   |
| Аймаг, сумдын ИТХ-аас Газрын тухай хуулийн хэрэгжилтэд тавих дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажиллах | Дуудлага худалдаа хуулийн дагуу зохион байгуулаагүй, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй, 2 жил дараалан газраа ашиглаагүй, гэрээнд заасан зориулалтын дагуу газраа эзэмшээгүй, газрын төлбөрөө төсөвт төвлөрүүлээгүй газруудын газар эзэмших эрхийг хүчингүй болгох | Талбарын хувийн хэргийн баяжилтыг тогтмол хийж, баримт бичгийн эмх цэгцийг сайжруулах, сумдын газрын даамлыг мэргэжил арга зүйгээр удирдаж, ажлын сахилга хариуцлагыг дээшлүүлэн жигд ажиллагааг хангах |
|  |  | Аймгийн хэмжээний газрын төлбөрийн ногдуулалт, төвлөрүүлэлтэд аймгийн татварын хэлтэс, сумдын газрын даамлуудтай хамтран зохион байгуулж, иж бүрэн хяналт хийх  |

Газрын тухай хуульд заасан холбогдох хяналтуудыг хэрэгжүүлэн ажиллах

Газрын хувийн хэргийн баяжилтыг ГХГЗЗГ-ын даргын 2016 оны А/169 тоот тушаалд заасны дагуу иж бүрдлийг хангуулан ажиллах

Аудитад шаардлагатай баримт мэдээллийг үнэн зөв гаргаж өгөөгүй, ажлын байрны тодорхойлолтод заагдсан үүргээ хангалтгүй биелүүлж байгаа газрын даамлуудад хариуцлага тооцон ажиллах

Эх сурвалж нь: Аймгийн аудитын газрын 2019 оны нийцлийн аудитын тайлан

2.2.13 Өмнөх аудитаар өгөгдсөн шийдвэрийн биелэлтийг хугацаанд ирүүлсэн ч бодит байдал дээр хэрэгжилт хангагдаагүй, ГХБХБГ газар бодлого, арга зүйгээр хангах чиг үүргийн байгууллага ч мэргэжилтнүүдийн ажлын хариуцлага сул, аудитад шаардлагатай тоо мэдээллийг тухай бүрд нь ирүүлдэггүй, удаа дараа шаардуулж байж өгдөг, дотоод хяналт хэрэгжүүлээгүй, албан хаагчдын хариуцлага сул байна.

**ДҮГНЭЛТ:**

**Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.**

1. Аймаг хөгжүүлэх үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт газрын харилцаатай асуудлыг тусгасан ч хэрэгжилт бүрэн хангагдаагүй байна
2. Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хууль журамд нийцүүлсэн баталсан ч зарим сумууд сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө батлуулаагүй байгаа нь цаашид газар олгох боломжгүй байдал үүсч байна.
3. Аймаг, сумдын газар зохион байгуулалтын төлөвлөгөөг тооцоо судалгаанд үндэслээгүйгээс төлөвлөгөөний биелэлт хангагдаагүй, өмнөх оны төлөвлөгөөнд үндэслэн газар олгож байгаа нь газрын тухай хуулийн хэрэгжилт хангагдахгүй байх нөхцөл бүрдэж байна.
4. Газрын хуулийн хэрэгжилт хангалтгүйгээс аймгийн нийт хүн амын 27.8 хувь нь гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газрыг өмчилж авсан байна.
5. Аймгийн ГХБХБГ-тай хамтран Булган, Жаргалант сумуудад газар эзэмшүүлэх, өмчлүүлэхтэй холбоотой зөрчлийг арилгах талаар тодорхой ажлуудыг зохион байгуулан ажилласан ч зөрчил бүрэн арилахгүй байгаа тул хяналтыг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.
6. Гэр, орон сууц, хашааны зориулалтаас бусад зориулалтаар газрыг олгохдоо дуудлага худалдаа зохион байгуулаагүйгээс орон нутгийн төсөвт оруулах орлогыг бүрэн бүрдүүлээгүй байна
7. Төрийн байгууллагуудын эзэмшлийн газрыг хуулийн холбогдох заалтыг зөрчин бусдад эзэмшүүлсэн зөрчлийг арилгах зорилгоор газар эзэмших зөвшөөрлийг хүчингүй болгосон ч газрыг чөлөөлөөгүй үргэлжлүүлэн эзэмшиж, ашиглаж байгаа нь ГХБХБГ хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлээгүй байгааг харуулж байна.
8. Уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ААН байгууллагын газрын төлбөрийн орлогыг дутуу ногдуулсан, газар эзэмших, ашиглах эрхээ бусдад шилжүүлэхдээ эрх борлуулсны орлогод татвар ногдуулаагүй нь төсвийн орлого бүрдүүлэх боломжийг алджээ.
9. Газрын тухай хуульд заасны дагуу аймаг, сумдын ИТХ болон Засаг дарга нь хяналт хэрэгжүүлээгүй, ГХБХБГ-аас сумдад хяналтыг хэрэгжүүлсэн ч хяналтын үр нөлөө гараагүй байна.

10. Газрын мэдээллийн системд 22,556 нэгж талбарын мэдээллийг оруулсан ч газрын мэдээллийн системд мэдээллийг бүрэн оруулаагүйгээс газрын төлбөрийн орлогыг дутуу ногдуулах, тайлан мэдээг бүрэн бус гаргах эрсдэл байна.
11. Өмнөх аудитын шийдвэрийн хэрэгжилт бүрэн хангагдаагүй, мэргэжилтнүүдийн ажлын хариуцлага хангалтгүй байна.

## ХОВД АЙМАГ ДАХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### АУДИТЫН ЗӨВЛӨМЖ:

Гүйцэтгэлийн аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

#### Аймгийн ИТХ-ын дарга-д

- Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолд заасны дагуу шугам, сүлжээ, дулаан цэвэр усны шугам сүлжээнд газрын төлбөрийг ногдуулан батлах
- Газар олголт, ашиглалтын үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлэн үр дүнг тооцон хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэр гаргаж байх
- Төсөл сонгон шалгаруулалтаар газар олгох шийдвэр гаргахдаа Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэгт заасныг мөрдөн ажиллах

#### Аймаг, сумдын Засаг дарга нарт

- Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг зөрчин газар олгохгүй байх, мөрдөн ажиллах, сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах, батлуулах
- Аймаг хөгжүүлэх үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт газрын харилцааны талаар тусгасан асуудал, газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих, биелэлтийг тооцон ажиллах
- Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг судалгаа тооцоонд үндэслэн төлөвлөх, газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй газар олгохгүй байх

#### Жаргалант сумын Засаг даргад

- Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу газрыг эзэмшүүлэх ашиглуулах, өмчлүүлэх асуудлыг шийдвэрлэж, өмнөх оны төлөвлөгөөнд үндэслэн газар олгохгүй байх
- Сумдын хилийн цэс зөрчин газар олгохгүй, газрын зориулалтыг өөрчлөхдөө газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх
- Газрыг эзэмшүүлэх захирамжид газрын хэмжээ, хугацааг тодорхой тусган, газар ашиглуулах шийдвэрийг газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх

#### Буянт сумын Засаг даргад

- Вестерн холд ХХК-ын ашиглаж байгаа шохойн ордын газрыг газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах

#### ГХБХБГ-ын даргад

- Газрын төлбөрийг бүрэн ногдуулах талаар цахим мэдээллийн системд мэдээллийг бүрэн оруулж, гэрчилгээг шинэчлэх, улсын бүртгэлийн е-дугаарыг олгох асуудлыг эрчимжүүлэх
- Дулааны шугам сүлжээний дулаан дамжуулах төвийн 27 байршилд баригдсан барилгын газрыг гэрчилгээжүүлэн, төлбөр ногдуулах
- Газар эзэмших, ашиглах эрхээ бусдад шилжүүлсний орлогод татварыг бүрэн ногдуулж, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх, хяналт хэрэгжүүлэн ажиллах

- Газрын мэдээллийн санд нэгж талбар, талбайн хэмжээ, зориулалттай холбоотой мэдээллийг үнэн зөв оруулах,
- Нэгж талбарын хувийн хэргийн баяжилтыг тогтмол хийж, баримт бичгийн эмх цэгцтэй болгон архивын нэгж үүсгэх, иргэдээс ирүүлсэн өргөдөл хуульд заасны дагуу хүлээн авч бүртгэлжүүлэх
- Иргэдийн ирүүлсэн өргөдөл хүлээн авсан бүртгэлийг тухай бүрд нь он, сар, өдрөөр дараалуулан хөтлөх, газар олгох захирамжийг давхардуулан гаргахгүй байх
- Булган суманд үл хөдлөх хөрөнгө худалдсан маргаантай асуудлыг шийдвэрлэх

**Алдаа зөрчлийн нэгтгэлд шалгагдагч байгууллагаас ирүүлсэн санал, тайлбар:**

|    |                |   |  |
|----|----------------|---|--|
| 11 | 1.2.8          | 2023 онд Булган сумын газрын даамал нь Засаг даргын захирамжид ороогүй иргэнд 0.2511 га газрыг олгосон, сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаагүй А/97 дугаартай захирамжаар 0.8 га газрыг хийдийн зориулалтаар га газрыг олгосон, Засаг дарга сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд олгосон, Жаргалант сум 2022 онд Цэргийн ангийн бэлтгэлийн тусгаагүй байршилд хийдийн зориулалтаар газар олгосон асуудал нь хуулийн талбайн газарт давхцуулан 8 гудамжны 160 айлын 12.2 га газар байгууллагаар шалгагдаж байна.   | Булган сумын газрын даамал Засаг даргын захирамжид ороогүй иргэнд 0.2511 га газрыг олгосон, Засаг дарга сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд олгосон, Жаргалант сум 2022 онд Цэргийн ангийн бэлтгэлийн тусгаагүй байршилд хийдийн зориулалтаар газар олгосон асуудал нь хуулийн талбайн газарт давхцуулан 8 гудамжны 160 айлын 12.2 га газар байгууллагаар шалгагдаж байна.  |
| 12 | 1.2.13         | Булган сумын Засаг даргын 2023 оны А/39 дугаартай захирамжаар Минжит Булган хот тохижилт ОНӨААТҮГ-т 12 га газар эзэмшүүлсэн, А/102 дугаартай захирамжаар Байтаг багийн маттарын хөдөөд байрлах 12 га газрыг Минж булагт арвижих майнинг ХХК-д гаалийн хяналтын талбайн зориулалтаар эзэмших эрхийг шилжүүлсэн,  | Хуулийн байгууллагад шалгагдаж байгаа бөгөөд газрын даамал нь тайлбараа хүргүүлсэн байна.  |
| 13 | 1.2.18         | Дулааны шугамын газрыг эзэмших зөвшөөрөл аваагүй, дулааны шугам дээр /27 байршилд/ дулаан дамжуулах төв барьж ашигласан,  | Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 97 дугаар тогтоол "Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм"-ийн дагуу хамгаалалтын зурвас тогтоосон захирамж шийдвэр гараагүй ба тухайн аж ахуй нэгж байгууллагаас эзэмших эрхийн гэрчилгээ олгох журмын дагуу хүсэлт, газрын байршлын зураглалыг үндэслэн Тухайн жилийн төлөвлөгөөнд тусгах гэж заасны дагуу шийдвэрлэх боломжтой .   |
| 14 | 1.2.19, 1.2.20 | Газар эзэмших зөвшөөрөлгүйгээр 973.4 га газрыг ашигласан, Жаргалант сум болон бусад сумуудад 245.8 га газрыг олгосон хэмжээнээс илүү хэмжээгээр ашиглаж байна   | Газар эзэмшигч, ашиглагчийн мэдээллийг Газрын кадастрын цахим систем бүртгэснээр эрх бүхий этгээдийн зөвшөөрөлтэй хэмжээнээс илүү газар ашиглаж байгаа зөрчлүүдийг хуулийн хүрээнд шийдвэрлэж, зөрчлөө арилгах талаар мэдэгдэл өгч, албадан буулгах арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна.   |
| 15 | 1.2.21         | Буюнт сумын Засаг даргын 2016 оны А/29 дүгээр захирамжаар Хөвд Агро парк ХХК-д "агро парк" байгуулах зориулалтаар 1900 га олгосныг 2018 оны А/106 дугаар захирамжаар хүчингүй болгосон байхад 2022 онд хүчингүй захирамжаар цахим мэдээллийн санд оруулсан,   | Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.7 дэх заалтын дагуу анх олгосон захирамжийн дагуу газрын кадастрын мэдээллийн санд бүртгэсэн байна.  |
| 16 | 1.2.22         | Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаас бусад газруудад хуулиар зөвшөөрсөн хэмжээнээс илүү хэмжээний газруудад дуудлага худалдаа зохион байгуулалгүйгээр 301 нэгж талбар, 17646.7 га газар өргөдлөөр шийдвэрлэсэн   | Хавсралт 5 дугаар хүснэгтийн дагуу нэгж талбар тус бүрээр тайлбар бичиж хүргүүлсэн.  |
| 17 | 1.2.22         | Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар олгох газруудад дуудлага худалдаа зохион байгуулалгүйгээр 75 нэгж талбар, 84.41 га газар олгосон.   | Хавсралт хүснэгт 6-ийн дагуу нэгж талбар тус бүр дээр тайлбарыг бичиж хүргүүлсэн.  |
| 18 | 2.1.3          | Аймгийн нутаг дэвсгэрт олон улсын болон орон нутгийн Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 97 дугаар тогтоол "Эрчим хүчний шугам чанартай, аж ахуйн нэгж байгууллагын дотоодын зам, мэдээлэл сүлжээг хамгаалах дүрэм"-ийн дагуу хамгаалалтын зурвас тогтоосон захирамж холбооны шугам сүлжээ, эрчим хүчний шугам сүлжээ, дулаан шийдвэр гараагүй ба тухайн аж ахуй нэгж байгууллагаас эзэмших эрхийн цэвэр бохир усны шугам сүлжээний газрын төлбөрийн гэрчилгээ олгох журмын дагуу хүсэлт, газрын байршлын зураглалыг үндэслэн итгэлцүүрээр ногдуулаагүй  | Тухайн жилийн төлөвлөгөөнд тусгах гэж заасны дагуу шийдвэрлэх боломжтой .  |
| 19 | 2.1.4          | Буюнт сумын нутаг дэвсгэрт Вестерн холд ХХК-д шохойн 143.8 га газарт ашиглалтын тусгай зөвшөөрөл гарсан бөгөөд 2023 оны байдлаар уулын ажилд 7.8 га талбайг ашигласан байхад газрын мэдээллийн системд ороогүй,   | Ашиглалт малтмалын тусгай зөвшөөрлөө авсан хэдий ч газрын кадастрын мэдээллийн санд бүртгүүлэхийн тулд Газрын тухай хуулийн 32.3-д заасан баримт бичгийг бүрдүүлэн тухайн сумын ЗД-д гаргаагүй байна.  |
| 20 | 2.1.11         | Томоохон дүнтэй 39 эрх шилжүүлэлтийг түүвэрлэн үзэхэд газар эзэмших, ашиглах эрхээ бусдад шилжүүлсний орлогод ногдох дугаар зүйлийн 38.6-д заасны дагуу орлого бүрдүүлэлтийн татварын татварыг төлөөгүй, бага дүнгээр төлүүлсэн зөрчлүүд нийтлэг байгууллагатай хамтран төвлөрүүлэн ажиллаж, орлого ногдох албан татварын хэмжээг манайхаас тогтоож өгөх боломжгүй юм.  | Газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлэхдээ газрын тухай хуулийн 38 гэрчилгээ олгох журмын дагуу хүсэлт, газрын байршлын зураглалыг үндэслэн Тухайн жилийн төлөвлөгөөнд тусгах гэж заасны дагуу шийдвэрлэх боломжтой юм.  |
| 21 | 2.2.6          | Газрыг зориулалтын дагуу ашиглаагүй 30 нэгж талбарын 21.2 га газар байна.   | Газар эзэмшигч иргэн , аж ахуй нэгж байгууллага нь газрын тухай хуульд заасан эрх, үүргээ хэрэгжүүлэхгүй байна.  |
| 22 | 2.2.11         | Булган сумын газрын даамал нь цахим мэдээллийн санд 8 нэгж талбарын 81.4 га газрын зориулалт, 10 нэгж талбарын 54.1 га газрын зориулалт захирамжаас зөрүүтэй, 6 нэгж талбарын газар эзэмших жилийг захирамжид заасан хугацааг 15 жилээр илүү оруулсан, Цэцэг, Дарви, Жаргалант, Алтай сумдын газрын даамлууд мэдээллийн системд нэгж талбарын хэмжээ, захирамж, зориулалтын мэдээллийг зөрүүтэй оруулсан,   | Булган сумын Газрын даамал нь энэ асуудлаар өөрийн тайлбараа хүргүүлсэн байна.   |
| 23 | 2.2.11         | Жаргалант сумын нэгж талбарын хувийн хэргийн бүрдүүлэлт хангалтгүй, архивын нэгж болгоогүй, даамлын өрөөнд хадгалалт Жаргалант сумын 2 газрын даамлын ажлын ачаалал их, ажлын 5 хоногт иргэдийг хангалтгүй эмх цэгцгүй, Жаргалант сум 2023 онд газар олгох хүлээн авч асуудлыг шийдвэрлэх, мэдээллийн сан үүсгэх, Жаргалант сумын захирамж гаргахдаа А/350, А/352-А/356 хүртэлх дугаарыг Засаг даргаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу гадуур ажиллаж байгаа нь дотоод давхардуулан гаргасан, Алтай сумын газрын даамал холбогдох хувийн хэрэг бүрдүүлэх, архив үүсгэхэд ажлын цаг хүрэлцэхгүй байна. Сумдын судалгааг ирүүлээгүй, Булган сумын газрын даамал судалгаа газрын даамлуудад мэргэжил арга зүйн зөвлөгөөг тухай бүрт нь өгч ажилласан. бүрэн гаргаж ирүүлээгүй, | Жаргалант сумын 2 газрын даамлын ажлын ачаалал их, ажлын 5 хоногт иргэдийг хангалтгүй эмх цэгцгүй, Жаргалант сум 2023 онд газар олгох хүлээн авч асуудлыг шийдвэрлэх, мэдээллийн сан үүсгэх, Жаргалант сумын захирамж гаргахдаа А/350, А/352-А/356 хүртэлх дугаарыг Засаг даргаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу гадуур ажиллаж байгаа нь дотоод давхардуулан гаргасан, Алтай сумын газрын даамал холбогдох хувийн хэрэг бүрдүүлэх, архив үүсгэхэд ажлын цаг хүрэлцэхгүй байна. Сумдын судалгааг ирүүлээгүй, Булган сумын газрын даамал судалгаа газрын даамлуудад мэргэжил арга зүйн зөвлөгөөг тухай бүрт нь өгч ажилласан. бүрэн гаргаж ирүүлээгүй, |

**Зөрчлийн нэгтгэлд ирүүлсэн санал тайлбарт ТАГ-аас хариу хүргүүлсэн тайлбар:**

Газар олголт, газрын төлбөрийн ногдуулалт, бүрдүүлэлтийн үр дүнд хийсэн аудитын тайлан

| аудитын д/д тайлангийн заалт | Алдаа, зөрчлийн товч утга   | ирүүлсэн санал, тайлбарын утга  |
|------------------------------|---|---|
| 1 1.1.4                      | Аймаг хөгжүүлэх үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт газрын харилцаатай холбоотой асуудлыг тусгасан ч хэрэгжилтийг тооцоогүй зарим ажил хийгдээгүй тухайлбал: Алтан орд констракшн ХХК-тай 2022 онд гүйцэтгүүлэхээр байгуулсан ч ажлаа хүлээлгэн өгөөгүй  | Аймгийн Засаг даргын тамгын газрын хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсээс тодруулах.  |
| 2 1.1.5                      | Дөргөн, Манхан, Алтай, Жаргалант сумаас бусад сумууд сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгүгээс газар зохион байгуулалтыг хэрэгжүүлсэн   | Газрын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.2 -д Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө зохиогдоогүй хот, тосгон, бусад сууринд газар эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг тухайн засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг үндэслэн энэ хуульд заасны дагуу шийдвэрлэнэ гэж заасны дагуу 21.2-д ИТХ-аар хэлэлцүүлэн баталсан тухайн жилийн ГЗБ-ын төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлсэн.      |
| 3 1.1.7                      | Ховд хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд нийцээгүй 5 нэгж талбарт газар олгосон /Ногоон байгууламжаар тусгасан газарт Хот хөгжлийн төлөвлөгөөнд ногоон байгууламжаар тусгагдсан 5 байршилд Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор, 5-8 олгосон газруудын зориулалтыг сумын ЗД-ын захирамжаар өөрчилж, хот давхар нийтийн орон сууц зориулалтаар, Өв соёлын хүрээлэн хөгжлийн төлөвлөгөөтэй нийцүүлэн эзэмшүүлэх боломжтой. Цамбагарав баг байгуулахаар төлөвлөсөн газарт сурын харвааны бэлтгэлийн Прогресс сургуулийн арын уулзварт байрлах газрыг Хот хөгжлийн төлөвлөгөө талбайн газар, Хар ус нуурын сав газрын захиргаанд сургалт батлагдахаас өмнө гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчлүүлсэн. Авид үйлдвэрлэлийн барилгын зориулалтаар, Цамбагарав багт худалдааны төвийн дээд талд сургууль, цэцэрлэгийн барилга барихаар цэцэрлэгийн барилга барихаар төлөвлөсөн газарт орон сууцны газрыг дахин төлөвлөлтөнд оруулж, сургууль дээр нь газрын зориулалт барилгын зөвшөөрөл олгосон, Жаргалант сумын 1-р сургуулийн өөрчилж, 1700 метр квадрат газрыг орон сууцны зориулалттай болгосон. хашаанд орон сууц барих зөвшөөрөл олгосон/ |   |
| 4 1.1.15, 1.1.18             | Аймгийн хэмжээнд 2019-2023 онуудад газар зохион АИМГИЙН ИТХ-ын 2019 оны 10 дугаар хуралдааны 8 дугаар тогтоолын 3 байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй 18 нэгж талбарын 16.8 хавсралтаар Малчны хороолол 1-7 гудамж төлөвлөгдсөний дагуу 6 нэгж га газрыг олгосон, 2023 онд Цамбагарав багт 135 иргэний 10.2 талбарыг олгосон, 2023 онд Цамбагарав багт 135 иргэнд 10.2 га газрыг 2022 оны га, Бичигт багт 4 иргэний 0,35 га, Буянт багт 7 иргэний 0,36 га сумын ИТХ-ын тогтоолоор баталсан ГЗБТ-ний дагуу он дамжин захирамж нь газрыг өмнөх оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөгөөр гарсан, 2 иргэнд өмч хувьчлалаар үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээг үндэслэн газрыг нь баталгаажуулсан хуучин олголт байсан.   |   |
| 5 1.1.16                     | Жаргалант сумын шинэ суурьшлын бүсэд хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу олгох газрыг газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгалгүйгээр, дуудлага худалдаа зарлалгүйгээр төсөл шалгаруулалтаар 23 ААН, иргэнд 15 га газрыг шинээр, 1 ААН-ийн 15 га газрын ашиглах хугацааг сунгасан байна.   | Аймгийн ИТХ-ын 2019 оны 10 дугаар хуралдааны 8 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар Хаус хороололоор Бугат багт төсөл сонгон шалгаруулалтаар 4.4 га газар батлагдсан, мөн 2022 оны 12 дугаар сарын 4-ны 5/09 хуралдааны 19 дүгээр хавсралтаар 6 га газрын төсөл сонгон шалгаруулалтаар батлагдсан.   |
| 6 1.1.17                     | Газрын тухай хуулийн 21.4.3-д заалтыг зөрчин нутаг дэвсгэрийн хилийн цэс зөрчин өөр сумын нутаг дэвсгэрт 88 нэгж талбар, 13.4 га газар олгосон.   | Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 110 дугаар тогтоолоор Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийг хэрэглээнд нэвтрүүлсэн бөгөөд үүнтэй холбоотойгоор цахим системд сумдын хилийн цэс орсон. Жаргалант сумын тэг гортитой ойролцоо сумдын нутаг дэвсгэрт тухайн үеийн Засаг даргын захирамжаар олгогдсон зөрчлийг ерөнхий газрын зөвлөмжийн дагуу хуулийн хүрээнд шийдвэрлэн ажиллаж байна.     |
| 7 1.1.19                     | Засаг дарга нь 7 нэгж талбарын 27 га газрын зориулалт өөрчлөхдөө газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3 дахь заалтын дагуу газар зохион байгуулалт хийгээгүй, тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгалгүйгээр захирамж гаргасан   | Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 5 дугаар зүйлийн 5.1.3.5. Газар ашиглалтын зориулалт өөрчлөх, 8 дугаар зүйлийн 8.1.9 дэх газар ашиглалтын зориулалт өөрчлөх тухай арх бүхий этгээдийн шийдвэрийг үндэслэн шийдвэрлэсэн бөгөөд тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгах шаардлагагүй. |
| 8 1.1.20                     | Газар олголттой холбоотой аймгийн ГХБХБГ-ын албан хаагчдын дансны хуульг түүвэрлэхэд иргэд, ААНБ-аас албан тушаалаа ашигласан мөнгө хүлээн авсан байж болзошгүй асуудал байна.  | Тус газрын хэдэн албан хаагчийн дансны мэдээллийг шалгуулахаар хуулийн байгууллагад өгсөн талаар мэдээлэл авах  |
| 9 1.2.3                      | Булган сумын Засаг даргад Их цоохор ХХК нь газрын хэмжээг өөрчлөх талаар 2020 оны 10 дугаар сарын 22-ны 08 дугаартай албан бичгээр хүсэлт уламжилсан боловч өнөөдрийг хүртэл шийдвэрлээгүй, Жаргалант сум иргэдээс ирсэн өргөдлийг хүлээн авахдаа он, сар, өдөр, цаг, минутаар бүртгээгүй, газар олголтыг өргөдлийн дараалал шийдвэрлэж байгаа эсэх нь Булган сумын Бүрэнхайрхан багийн иргэн Б нь 2024 оны 08 дугаар сард үл хөдлөх эд хөрөнгө худалдах, худалдан авах (Өмчлөлийн газар) гэрээгээр 1000 м2 газрыг иргэн Г-д худалдсан боловч мөнгийг өөрөө аваагүй газрын даамлын нөхрийн дансаар авсан.   | Булган сумын Газрын даамал нь энэ асуудлаар өөрийн санал, тайлбараа хүргүүлсэн байна.   |
| 10 1.2.9                     | Булган сумын Бүрэнхайрхан багийн иргэн Б нь 2024 оны 08 дугаар сард үл хөдлөх эд хөрөнгө худалдах, худалдан авах (Өмчлөлийн газар) гэрээгээр 1000 м2 газрыг иргэн Г-д худалдсан боловч мөнгийг өөрөө аваагүй газрын даамлын нөхрийн дансаар авсан.  | Булган сумын Газрын даамал нь энэ асуудлаар өөрийн санал, тайлбараа хүргүүлсэн байна.   |

## Газар олголт, газрын төлбөрийн ногдуулалт, бүрдүүлэлтийн үр дүнд хийсэн аудитын тайлан

| аудитын тайлангийн заалт | ирүүлсэн санал, тайлбарын утга   | шийдвэрлэлт   |
|--------------------------|--|---|
| 1.1.4                    | Аймгийн Засаг даргын тамгын газрын хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсээс тодруулах.   | Саналыг хүлээн авах боломжгүй   |
| 1.1.5                    | Газрын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.2 -д Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө зохиогдоогүй хот, тосгон, бусад сууринд газар эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг тухайн засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг үндэслэн энэ хуульд заасны дагуу шийдвэрлэнэ гэж заасны дагуу 21.2-д ИТХ-аар хэлэлцүүлэн баталсан тухайн жилийн ГЗБ-ын төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлсэн.   | Саналыг хүлээн авах боломжгүй   |
| 1.1.7                    | Хот хөгжлийн төлөвлөгөөнд ногоон байгууламжаар тусгагдсан 5 байршилд олгосон газруудын зориулалтыг сумын ЗД-ын захирамжаар өөрчилж, хот хөгжлийн төлөвлөгөөтэй нийцүүлэн эзэмшүүлэх боломжтой. Цамбагарав баг Прогресс сургуулийн арын уулзварт байрлах газрыг Хот хөгжлийн төлөвлөгөө батлагдахаас өмнө гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчлүүлсэн. Авид худалдааны төвийн дээд талд сургууль, цэцэрлэгийн барилга барихаар төлөвлөсөн газарт, Жинчидийн жинчид ХХК нь орон сууцны барилга барих зөвшөөрөл аваагүй барилга угсралтын үйл ажиллагаа явуулсан болно. Жаргалант сумын 1-р сургуулийн хашаанд хуучин багш ажилчдын байр байсан газрыг дахин төлөвлөлтөнд оруулж, сургууль дээр нь газрын зориулалт өөрчилж, 1700 метр квадрат газрыг орон сууцны зориулалттай болгосон. | Шалгуурыг тусгасан ч хүрэх түвшинг нарийвчлан тусгаагүй тул саналыг хүлээн авах боломжгүй   |
| 1.1.15,                  | Аймгийн ИТХ-ын 2019 оны 10 дугаар хуралдааны 8 дугаар тогтоолын 3 хавсралтаар Малчны хороолол 1-7 гудамж төлөвлөгдсөний дагуу 6 нэгж талбарыг олгосон, 2023 онд Цамбагарав багт 135 иргэнд 10.2 га газрыг 2022 оны сумын ИТХ-ын тогтоолоор баталсан ГЗБТ-ний дагуу он дамжин захирамж нь гарсан, 2 иргэнд өмч хувьчлалаар үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээг үндэслэн газрыг нь баталгаажуулсан хуучин олголт байсан.  | Жаргалант сумын ЗДТ-т 2021 онд олгосон 11.4 га газартай холбоотой саналыг хүлээн авч залруулсан. Бусад саналыг хүлээн авах боломжгүй тул хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах.   |
| 1.1.16                   | Аймгийн ИТХ-ын 2019 оны 10 дугаар хуралдааны 8 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар Хаус хороололоор Бугат багт төсөл сонгон шалгаруулалтаар 4.4 га газар батлагдсан, мөн 2022 оны 12 дугаар сарын 4-ны 5/09 хуралдааны 19 дүгээр хавсралтаар 6 га газрын төсөл сонгон шалгаруулалтаар батлагдсан.  | Газар зохион байгуулалтын 2021 оны жилийн төлөвлөгөөнд тусгаагүй, 2020 онд төлөвлөснөөс илүү хэмжээгээр төсөл шалгаруулалтаар олгосон, 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж 4.8 га газар олгох тухай захирамж гаргасан харин хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг 6 дугаар сард баталсан гэсэн утгаар тайланд оруулсан |
| 1.1.17                   | Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 110 дугаар тогтоолоор Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийг хэрэглээнд нэвтрүүлсэн бөгөөд үүнтэй холбоотойгоор цахим системд сумдын хилийн цэс орсон. Жаргалант сумын тэг гортигтой ойролцоо сумдын нутаг дэвсгэрт тухайн үеийн Засаг даргын захирамжаар олгогдсон зөрчлийг ерөнхий газрын зөвлөмжийн дагуу хуулийн хүрээнд шийдвэрлэн ажиллаж байна.   | Саналыг хүлээн авах боломжгүй   |
